

Шашны асуудлаарх Монгол төрийн бодлогын гүн ухаан

Магсаржавын Гантуяа, доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс, gantuya_m@mas.ac.mn; <https://orcid.org/0000-0003-0414-8494>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-20

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

улс төрийн бодлого, үашны асуудал, шашны гүн ухаан, бодлогын гүн ухаан, шашин судлал

Хураангуй: Сүүлийн үед төр, шашны харилцааны асуудал олны анхаарлыг ихээр татах болов. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нийгэмд улам бүр бодтой бүрэлдэхийн хэрээр шашны асуудалд хандах төрийн бодлогыг боловсронгуй болгох шаардлага тэр хэмжээгээр өссөөр байна. Энд шашны талаарх дараах асуудлыг Монгол төрөөс хэрхэн шийдвэрлэж ирсэн болон шийдвэрлэж байгааг авч үзэх болно. Үүнд: 1. “Төрийн бодлого”, “Шашны асуудал”, “Гүн ухааны үүднээс үүднээс авч үзэх хандлага” гэсэн ойлголтуудын мөн чанар, харилцан хамаарал; 2. Төр ба шашны адил ба ялгаатай талыг мэргэд хэрхэн тодорхойлж ирсэн тухай; 3. Төрийн хууль ба шашны номлол, тэдгээрийн тус тусын бие даасан байдал ба харилцан хамаарал; 4. Шашин бол нийгмийн оюун санааны амьдралын салшгүй хэсэг болох нь; 5. Шашин ба үндэсний боловсрол; 6. Шашин ба нийгмийн ёс суртахуун; 7. Шашин ба иргэний боловсрол; 8. Шашны асуудалд хандах төрийн бодлогын мөн чанар.

Төр нь нийгмийн харилцааг төрийн хуулиар зохицуулж, иргэддээ төрийн хууль дүрмийг заавал биелүүлэхийг шаарддаг, хэрэгжилтэнд хяналт тавьдаг бол шашин нь нийгмийн хөгжилд улам бүр тодорхойлогч үүрэг гүйцэтгэж байгаа нийгмийн оюун санааны амьдралын салшгүй хэсэг болж, хувь хүмүүсийн амьдралын утга учир, үнэнийг эрэлхийлэх танин мэдэхүйн хэрэгцээ, оюун санааны чөлөөт сонголтыг хангах нэгэн томоохон хүч болж байна. Энэ тохиолдолд шашны асуудлыг олон талт судалгаа шинжилгээнд тулгуурласан шинжлэх ухаанч арга зүйгээр шийдвэрлэх гүн ухааны бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Монголын төрөөс шашны талаар явуулж ирсэн зарим уламжлалт гүн ухааны хандлагыг түүхчлэн тайлбарлахыг хичээе.

Keywords

*political policy,
religious issues,
religious philosophy,
political philosophy,
religious studies*

© The Author(s), 2024



Philosophy of Mongolian state policy on religious issues

Gantuya Magsarjav (Sc.D), professor

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, gantuya_m@mas.ac.mn; <https://orcid.org/0000-0003-0414-8494>

Abstract: The issue of state-religious relations has recently attracted considerable attention. As religious freedom and non-religion become more and more common in society, it is necessary to improve the state's religious policy. Here we will examine how the Mongolian Government has solved the following religious issues. It includes: 1. *The nature and interaction of the concepts of state policy, religious issues, and philosophical approach*; 2. *How wise men define similarities and differences between state and religion*; 3. *State laws and religious missions, their independence and interdependence*; 4. *Religion is an integral part of society's spiritual life*; 5. *Religion and national consciousness*; 6. *Religion and social morality*; 7. *Religion and civil education*; 8. *State policy on religious issues*. The State regulates social relations through state legislation, requires citizens to comply with state laws, and oversees their implementation, and religion increasingly plays a crucial role in the spiritual life of society, and is increasingly defining the cognitive needs of individuals searching for meanings and truths. It has become an important force for free spiritual choice. In this case, a philosophical policy should be developed and implemented to solve religious problems through multidisciplinary scientific methods. We must try to explain historical principles of the Mongolian government's traditional philosophical approach to religion.

I. Оршил

1990-ээд оноос хойш шашин шүтэх болон эс шүтэх эрх чөлөө нийгмийн амьдралд бодитой хэрэгжиж буйд нийтээрээ талархалтай хандаж байгаа билээ. Үүнтэй зэрэгцээд уламжлалт шашнууд сэргэн хөгжиж, мөн урьд өмнө монголчуудын дунд тэр бүр дэлгэрч байгаагүй шинэ шашнууд Монгол газраа бий болсоор байна. Гэсэн хэдий ч шашны олон янз байдал бий болсноор нийгмийн оюун санааны ертөнцөд олон ургальч хандлага хөгжиж байна гэж нэг хэсэг нь үзэж байхад, нөгөө хэсэг нь энэ үйл явцыг монголчуудын үзэл санааны дотоод эв нэгдлийг бусниулах сөрөг хандлага байж болох юм хэмээн болгоомжилж байгаа юм. Ямартай ч

Монголын төр шашны асуудалд эрт дээр цагаас анхаарлаа хандуулж ирсэн уламжлалтай.

Ер нь ямар ч төр улс иргэдийнхээ аюулгүй амьдарч хөдөлмөрлөх, аж төрөх орчин нөхцлийг хангах, сэтгэл санааны амар тайван байдлыг бий болгоход хүчин чармайлт гаргах үүрэгтэй билээ. Чингэхдээ шашинд хандах хандлагаараа шашныг төрөөс дээгүүр үзэх, шашин ба төр ижил байр сууринд байх, төр, шашин хоёр тусгаарлагдсан гэсэн үндсэн гурван төрлийн хандлагыг авч үзэж болох юм. Үүнээс сүүлийн хандлагыг ихэнх улс гүрнүүд баримталдаг ч, жишээ нь Иранд, шашин нь төрийн үүргийг гүйцэтгэдэг теократ засаглалтай ажээ. Харин Их Британи, Испани, Польшид

Христийн шашин нь төрийн үйл хэргийг явуулдаггүй ч төрийн шашин, төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн давуу эрхтэй шашин хэмээн албан ёсоор хуульчлагдсан байдаг. Ихэнх улсад төр нь шашнаас бүрмөсөн тусгаарлагдсан байх ба энэ хандлага нь шашны асуудлыг төрөөс шийдвэрлэхэд хамгийн зохимжтой арга зам гэж үздэг. Ийм секуляр улсуудад шашин, төр хоёр ямар ч хамааралгүй бүрэн тусгаар байдаг гэвэл бас ч тийм биш, харин нэг нэгнээ дэмжиж, хамгаалж байдаг юм. *Төр нь шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөг хамгаалж дэмжиж байхад шашин нь төрийнхөө тусгаар тогтнол, иргэдийн амар тайван байдлыг хамгаалахад хүчин зүтгэж байвал төр, шашны харилцаа сая зөв явагдаж байна гэж үзэж болох юм.*

Орчин үеийн нийгмийн харилцаанд бий болоод байгаа олон ээдрээтэй асуудлыг шийдвэрлэхэд улс төр, эдийн засгийг хөгжүүлэх гэхээсээ илүү нийгмийн оюун санааны амьдралыг дэмжин тогтворжуулах асуудал улам бүр чухал болж байна. Нийгмийн оюун санааны амьдралын салшгүй томоохон хэсэг нь шашин шүтлэг байдаг тул төрт улсууд шашны асуудалд аль болох нааштай хандах сонирхол нэмэгдэж байна. Шашныг нийгмийн сэтгэл санааны нэгээхэн хэсэг болгож авч үзэх хандлагыг Монголын эртний төрт улсууд, эзэнт гүрний үед онцгойлон үзүүлж байсан бөгөөд чухам энэ нь тэдний амжилтын нэг чухал үндэс болсон нь гарцаагүй. Шашин шүтлэг нь иргэдийн хувийн амьдралыг олон талаар тодорхойлдог болохыг орчин үеийн шашны сэтгэлзүйд ч судлан тогтоосоор байна.

Төрөөс шашны асуудлыг хамгийн зөв арга замаар шийдвэрлэх, шашны байгууллага, сүсэгтэн хүмүүстэй харилцах хамгийн зөв хандлагаа тогтоохын тулд Шашин судлалыг шинжлэх ухааны салбар болох хувьд нь дэмжин хөгжүүлж, шашин судлаачдыг шашны асуудал эрхэлсэн төрийн үйл хэрэгт татан оролцуулах зайлшгүй шаардлага улам бүр өсөж байна. Шашин судлал нь шашнаас ангид тусдаа байж, шашныг олон талаас судлан объектив мөн чанарыг тодорхойлох шинжлэх ухааны салбар болохоос шашныг баримталдаг, эсвэл шүүмжилдэг байр суурьтай субъект биш юм. Энэ утгаараа төр нь шашны асуудалд хандахдаа шашин судлалын шинжилгээ судалгааг үндэс болговол зохино.

Бид 2004 онд анх удаа шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөний асуудлыг шинжлэх ухааны үүднээс, тухайлбал шашин судлалын үүднээс тодорхойлох зорилгоор Монгол дахь НҮБХХ-ийн Хүний эрхийг хангах төсөлтэй хамтран, философи, түүх, социологи гэх мэт олон талын мэргэжлийн эрдэмтдийг оролцуулан МУИС-ийн Шашин судлалын тэнхмээс эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан билээ. Энэхүү хуралд Монголын болон Буддын гүн ухаан судлаач, тухайн үеийн МУИС-ийн Шашин судлалын тэнхмийн эрхлэгч агсан доктор Г.Лхагвасүрэн “Шашны талаарх Монгол төрийн бодлогын уламжлалаас”¹ хэмээх илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд тэрхүү илтгэлдээ: “*Монгол төрийн мандал, буурлын аль ч үед шашны асуудал төрийн бодлогод ямар нэгэн*

¹ Г.Лхагвасүрэн. Шашны талаарх Монгол төрийн бодлогын уламжлалаас / Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө. Ред. М.Гантуяа. УБ. 2004. Х.51

хоёрдугаар зэргийн, тохиолдлын мэт зүйл байсангүй. Харин ч нийт нийгмийг оюуны хувьд нь нэгтгэн нягтруулах, үндэсний өвөрмөц дүр төрх, оюуны тусгаар тогтнолоо хадгалан бэхжүүлэх нэгэн гол хүчин болох хувьд нь шашны асуудлыг авч үздэг байжээ. төрийн байгуулал, шашин сүм хийдийн байгуулал хоёрыг зэрэгцүүлэн босгож, шашнаа уг номын нь ёсоор явуулах үндсэн дээр төрийн албадлагын хүчийг шашин номын хүчин лүгээ хавсаргаж, тэр хоёр бие биеэ нөхөн гүйцээж,

1. Балар эрт үе
2. Түүрүү улсын үе
3. Эзэнт гүрний үе
4. Бутралын үе
5. Манжийн ноёрхлын үе
6. Богд хаант засгийн үе
7. Социалист систем
8. Ардчилсан өөрчлөлт

Монгол газар хүн бий болсон цагаас шашин шүтлэг байсан ул мөр олдсоор байна. Орчин цагийн хүмүүс ойролцоогоор 74000 жилийн тэртээд бий болсон гэх тайлбар байдаг ч (Cavalli-Sforza L.L., Feldman M.W. 2003, 266-275)^{2*} Монгол орны нутаг дэвсгэрт доод палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үе, одоогоос 800000 жилийн тэртээгээс хүн амьдарч байсан тухай мэдээ үлджээ^{3*} (ШУА, Түүхийн хүрээлэн 2004, 57) Балар эртний хүн төрөлхтөний түүхийн эхэн үе буюу нийгмийн хөгжил нэн сул дорой байх цаг үед зөвхөн эх хүн л үр хүүхдээ хамгаалах, өсгөн бойжуулах, хооллох ундлах, оромж агуй олж суурьших гэж тэмцэн тэмтрэн байсан ажгуу. Энэ

шүтэн барилдаж чадсан цагт сая төр улс төвшин бөгөөд амгалан болж чадна гэж үздэгт шашны талаарх Монгол төрийн уламжлалт бодлогын гол зүйл орших юм гэж үзэж байна” хэмээн шашны талаар явуулж ирсэн Монгол төрийн уламжлалт бодлогыг тодорхойлсон байдаг.

Шашны асуудалд холбогдох эртний Монгол төрийн хөгжлийн түүхэн үе шатыг дараах байдлаар ангилж болно:

- Овгийн тэнгэр шүтлэг
- Тэнгэр шүтлэг ба Буддын гүн ухаан
- Мөнх тэнгэр шүтлэг ба Сажаван ёс
- Бөө мөргөл ба Буддын шашин
- Гэлүмба шашны мэдлэг ухаан
- Гэлүмба шашинт төр
- Марксист атеизм
- Гэлүмба давамгайлсан олон шашин, атеизм

эрт балар үеэс л эх хүнийг “тэжээгч”, “өсгөгч”, “хайрлагч”, “хамгаалагч”-ийн бэлгэдэл гэж өдгөө хүртэл дээдэлж ирсэн юм. Эрт балар үеийн “овгийн байгууллын нэг чухал шинж нь эхийн эрхт ёсны үед бүлгээрээ гэр бүл болж байсныг хязгаарлан нэг овгийн дотор бэлгийн харьцааг хориглох болсон явдал буюу нэгэн эхээс гаралтай овгийн гишүүд өөр хоорондоо эр эм бололцохоо больж, харь овгийн охин богтлох, харь овогт хүргэн орох ёс үүссэн явдал юм. Энэ нь овог хоорондын ялгааг улам тодруулсан төдийгүй цаашдаа гэр бүлийн дэвшилтэт хэлбэр болох хос гэр бүлд шилжих, мөн хүний өөрийн нь удам угсааны цаашдын хөгжилд таатай

² * Около 74 000 лет назад небольшая популяция (ок. 2 000 человек), пережившая последствия очень мощного вулканического извержения (~20-30 лет зимы), предположительно вулкана Тоба в Индонезии, стала предком современных людей в Африке. Можно предположить, что 60 000—40 000 лет назад люди мигрировали в Азию, и оттуда в Европу (40 000 лет), Австралию и Америку (35 000—15 000 лет) // <https://ru.wikipedia.org/wiki/человек>

³ * Өнөөгийн Монгол Улсын нутгаас илрүүлэн олж судалсан хүний гараар хийгдсэн чулуун зэвсгийн дурсгалуудын хамгийн эртнийх нь палеолитын доод үе буюу одоогоос 750000-800000 жилийн тэртээд холбогдоно.

нөлөө үзүүлжээ” (ШУА, Түүхийн хүрээлэн 2004). Эхийг дээдлэх үзэлтэй хамт, эх хүн галыг анх хэрэглэж, гал голомтоо бадраасан цагаас гал шүтлэг, гал голомтыг дээдлэх үзэл бий болсон нь дамжиггүй. «Эмэгтэй хүн эрэгтэйчүүдээс илүү галны учрыг олж, мөн чанар, ааш араншинг нь тодорхойлж сурчээ... Тэрээр галтай холбоотой, ямар нэг хэмжээгээр үнэнд ойр хорио цээрүүдийг олноор нь тогтоож, нэлээд хэдэн шашны ойлголтуудыг бий болгожээ” (Харузина В.Н. 1906, 68), (Сергей Токарев. 1984) хэмээн Оросын судлаач В.Н.Харузина бичсэн байдаг.

Монголчуудын галын тахилгын үеэр уншдаг галын ерөөл магтаалд ч галыг анх хэн юуны тулд хэрэглэж эхэлсэн талаар төсөөлөл бий. Тухайлбал:

*“Галын хаан эх мину
Хангай ханыг дов байхын цагаас
Хамаг улсын үүдэхээс өмнө
Хамгийн эх болон заяасан
Галын хаан эхдээ
Арц шатаам, тос өөхөөр
Тахил дусаан суунам би.
Бурхад ханыг дов байхын цагаас
Бургас модыг найлзуурын үеэс
Бүгд улсыг үүдэхээс өмнө
Бүрний эзэн болон бүтсэн
Галын хаан эхдээ
Хар архи, халим өөхөн тосыг
Дусаан суунам би.
Эзэн тэнгэрийн дэлбээ цагаас
Этүгэн эхийн өлмийн үеэс
Өргөн их улсыг үүдэхүйеэ
Өрхөтийн эх болон заяасан
Галын хан эхийг тахинам би”^{4*}*

(Дамдинсүрэн Ц. 1959) хэмээчихүй.

Эмэгэхийн асаасан галыг үеийн үед унтраалгүй манаж, утааг нь таслахгүй ёс эхийг дээдлэх ёстой зэрэгцэн бий болсноор анх гал голомтоо бий болгосон дээд эмэг эхийн сүнсийг галаас нь, утаанаас нь холдуулахгүй байж, үр удамтай нь эгнэгт холбож, удам угсааг нь таслахгүй үргэлжлүүлэх үүрэгтэй утаа сахигч буюу удган охин гэх мэт бөө мөргөлд холбогдох ойлголт, зан үйл бий болсон байна. Нөгөө талаар, нэгэн голомтын дотор гэр бүл болох нь үр хүүхэд эрүүл чийрэг төрөхөд тусгүй болохыг аажимдаа ойлгосон балар эртний монголчууд холоос бэр буулгах ёсыг өдгөө хүртэл хадгалж ирсэн билээ. Энэ үеэс эцгийн эрхт ёс бий болж, эцгийн гал голомтыг тойрсон овгийн байгуулал үүссэн юм. Эхийн сүнс байгаль дэлхийд үлдэж, үр удмынхаа хоол тэжээл, амьрал ахуйг хариуцдаг бол, эцгийн сүнс дээрээс, тэнгэрээс овог аймгийнхаа алс ирээдүйн хувь заяаг нь хариуцна. Ийнхүү тэнгэр эцэг, газар эхийн тухай бөө мөргөлийн үзэл санаа бүрэлджээ. Монгол газраа эхийн эрхт ёс ба эцгийн эрхт ёс үүсэн бий болсон үйл явцтай зэрэгцэн бөө мөргөлийн үзэл санаа, зан үйл, ёс заншил бүрэлдсээр байв.

Гал голомтыг дээдлэх үзэл санаа эцгийн эрхт ёсонд шилжсэн үеэс овгийн буюу төрөл төрөгсөд нийлсэн арваад өрхийн ахлагч - аравтын ноёныг дээдлэх, арван аравтыг нэгтгэн удирдах зуутын ноёныг дээдлэх, арван зуутыг нэгтгэн удирдах мянганы ноёныг дээдлэх, арван мянганыг нэгтгэн удирдах түмний ноёныг дээдлэх, хэд хэдэн түмнийг нэгтгэсэн

^{4*} Галын ерөөл

төр улсын хааныг дээдлэх үзэл рүү аажмаар шилжсээр Хүннүгийн төр, цаашлаад Монголын эзэнт улсын үзэл санаа болж цар хүрээгээ тэлсэн билээ. Энэ үед ч эхийн болон эцгийн сэтгэл-сүнс буюу сахиусыг дээдлэх, гал голомт, газар нутаг, овог угсаа, төр улсаа хамгаалагч тэнгэр эцэг, газар эхийн шүтлэг хадгалагдсаар бүр XIII зуун буюу Монголын эзэнт улсын үетэй залгажээ.

Монголчуудын “Мөнх тэнгэр шүтлэгийн” гүн ухаан бүрэлдсэн үйл явцыг тайлбарлаж доктор Г.Лхагвасүрэн бичихдээ: «Бөөгийн шашин тэнгэр эцэг, газар эх хэмээн тэнгэр, газар хоёрыг шүтдэг, дээд 99 тэнгэр, доод 77 тэнгэр хэмээн олон тэнгэрийн санаа зоригийг номлодог байсан бол Их Монгол Улсын үе болж ирэхэд “Мөнх тэнгэрийн ивээлээр, тэнгэр газар эелэлдэн хүч аугаа нэмэгдэж, гүр улсыг төвшитгөн, гагц жолоонд оруулсан” (Цэрэнсодном Д. 1993, 208) гэх зэргээр өмнөх олон тодорхой тэнгэрүүд, тэнгэр, газар хоёроос давж гарсан бөгөөд эргээд тэдгээрийгээ ивээн тэтгэж байдаг, цаад язгуур үндэс нь болдог Мөнх хөх тэнгэр хэмээн цор ганц тэнгэрт шүтэн бишрэх болж ирсэн бололтой. ...Үнэндээ ч нэгэн тэнгэрт түгээмэл чанарыг л тулгуурлахгүйгээр нэгдсэн төр улсыг байгуулан бэхжүүлэхийн аргагүй юм. Мөнх тэнгэр нь газар, тэнгэр дэх бүхний язгуур үндэс, жам ёсныг заяан ивээгч түгээмэл чанар болно. Тэрхүү тэнгэрлэг чанарт шүтэж, түүнд дүйж очсон цагт л төр нь ч төр шиг, хаан нь ч хаан шиг байж сая чадмуй гэж Чингис хаанаас өгсүүлээд Их Монгол Улсын хаад гүнээ итгэн биширч байсан ажгуу» (Лхагвасүрэн

Г. 2004, 41-42) хэмээчихүй.

Нөгөө талаар, Монгол газраа бүр Хүннүгийн үеэс Буддын шашин дэлгэрсэн хэмээн түүхчид, археологичид нотолсоор байна. Гэхдээ эрт үед ч, өнөө үед ч Монголын нүүдлийн соёл иргэншлийг дагалдан зайлшгүй бий болсон үзэл суртал хэмээвээс байгаль орчлонгийн бүхий л үзэгдэл юмс, үйл хөдөлгөөнийг өөр хоорондоо нягт холбоотой шүтэн барилдаж оршино гэдгийг жилийн дөрвөн улиралд малаа даган нүүдэллэж, байгальтай шууд харьцах явцдаа танин мэдэж, ой ухаандаа шингээсэн гэдгийг мартаж болохгүй. Мал сүрэг нь өсөхийн хэрээр илүү их бэлчээр нутаг шаардаж, тэр хэрээр нүүдэлчин Монгол хүний оюун сэтгэлгээний цар хүрээ тэлж, өвөрмөц зохион байгуулалт бүхий нийгмийг цогцлоосон нь суурин иргэншлээс ялгарах нүүдлийн соёлын онцлог буюу. Ийнхүү монголчууд хөрш зэргэлдээх суурин ард түмнээс эрс ялгарах нүүдлийн соёл иргэншлийг цогцлоосон ч, газар газрын ард түмэнтэй худалдаа-соёлын өргөн харилцааг хөгжүүлэхийг эрхэмлэж ирсэн ба энэхүү гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа нь бусад ард түмний оюуны соёл, түүний дотор шашин суртахууныг судлан мэдэх өргөн боломжийг нээж байв. Монголчууд эртнээс Хятадын күнз, даогийн болон Өрнийн христ, исламын соёлтой нүүр тулж байсан ч, тэр олон үзэл суртал, шашин номлолоос Буддын сургаалыг илүүтэй эрхэмлэн дээдэлж ирсний шалтгаан нь угтаа нүүдлийн соёл иргэншлийн онцлогт л оршин байгаа юм. Өөрөөр хэлбэл, нүүдлийн соёлын хүрээнд бий болсон байгаль орчлон –

мал амьтан – хүн нийгмийг нэгэн цогц гэж үздэг ертөнцийг үзэх уламжлалт үзэл санаанд Буддын сургаал, ялангуяа түүний шүтэн барилдлагын сургаал нь хамгийн ойр дөт онол байсан учраас монголчууд эрт дээр үеэс Буддын шашныг, ялангуяа түүний гүн ухааны үзэл санааг өөрийн унаган үзэл суртал мэт дээдлэн хүндэлж иржээ. Ийнхүү нүүдэлчин монголчуудын олж мэдсэн янз бүрийн ард түмний олон янз сургаал онолоос чухам шүтэн барилдлагын тухай Буддын сургаал нүүдэлчдийн байгаль орчлонгийн талаархи цогц мэдлэгтэй зохицон нийлсэн нийлсэн ажгуу.

Буддын сурвалжуудад орчлонд Ганга мөрний хумхын тоосны тоот ертөнц байх ба тэдгээр хязгааргүй ертөнцөд мөн тийм хэмжээний хязгааргүй төрөлхтөн оршин байдаг, нийт төрөлхтөнийг дээд бодьсадвын төрөлхтөн, тэнгэр төрөлхтөн, хүмүүн төрөлхтөн, адгуус, там, бирд төрөлхтөн хэмээн үндсэн зургаан төрөлхтөн болгон авч үздэгийн дотор олон янз тэнгэр төрөлхтөний тухай үзэл номлол ч Монголчуудын тэнгэр шүтлэгийн үзэл санаанд нийцэж байв. Төрөлхтөнүүд өөр хоорондоо аалзны шүлс мэт учир шалтгааны холбоогоор шүтэн барилдаж холбогдохдоо үйлийн үрийн хуулинд захирагдана хэмээх Буддын сургаалын тайлбар нь монголчуудын тэнгэр эцэг, газар эхийн сүнс-сахиусыг дээдлэх байгалийг амьчлах үзэлтэй сүлэлдэн нийлэн юм.

XVII зуунаас эхлэн XX зууны эхэн хүртэл 300-аад жилийн турш монголчуудын дунд Буддын шашин үндсэн шашин шүтлэг нь болж ирсэн ч, Буддын шашныг Монголд гурвантаа дэлгэрсэн хэмээх уламжлалт түүх

бичлэгт үздэгээр, Монголын түүх (Хүннү, Сяньби, Нирун, Түрэг, Уйгур, Кидан) улсуудын үед Буддын шашны түүх дэлгэрэлт явагдсан, харин Монголын эзэнт гүрний үеийг дунд дэлгэрлийн үе, Алтан хан ба Төвдийн гуравдугаар Далай лам Содномжамц нар холбогдож гелүгбийн буюу шарын шашныг XVII зуунаас Монголд дэлгэрүүлсэн үеийг хожуу дэлгэрэлт гэдэг.

Түүх дэлгэрлийн үед шүтэн барилдлагын тухай Буддын гүн ухааныг Монголын нүүдлийн соёл иргэншилээс үүссэн эцэг-тэнгэр-огторгуй ба этүгэн-газар-дэлхийг нэгдмэл цогц байдлаар нь “Мөнх тэнгэр” хэмээх ойлголтод нэгтгэн дээдэлдэг гүн ухаантай хослуулан төрийн үзэл суртал болгож байсан баримт түүх-археологийн шинжлэх ухаанд улам бүр тодорсоор байна (Солонгод Л.Хурцбаатар. 2019).

Харин дунд дэлгэрлийн талаар судлаачид ярихдаа гол төлөв Хубилай хаан ба Пагва ламын үйл ажиллагааг гол болгон тайлбарладаг. Гэвч Төвдийн сажийн ёсыг Монгол төрийн бодлогод нийцүүлэн дэмжиж тэтгэсэн анхны хаан бол Ходан хаан билээ.

Гэхдээ бид Ходан хааны талаар, ер нь Монгол хаадын талаар гадны хэлээрх эх сурвалжуудын мэдээг, ялангуяа тэдний тайлбарыг судалгаандаа гарцаагүй үнэн тайлбар болгож авч хэрэглэхдээ болгоомжтой хандах нь зүй. Учир нь ихэнх тохиолдолд гадны хэлээрх эх сурвалжууд нь Монголын хаадын нэр хүндийг тухайн улс үндэстний дотор хэт өндөрт өргөхөөс зайлсхийсэн хандлагатай байдаг аж.

Ходан хааны талаар тусгайлан

судалсан судалгаа ховор ч, энд Оросын судлаач Р.Ю.Почекаевын судалгааг (Золотая орда обзор 2018) онцлон авч үзэх нь зүйтэй. Тэрээр Ходан хааны нэрийг эх сурвалжуудад Кутан, Кёдон, Ко-дуанг гэх мэтээр бичсэн байдаг ч монгол судлаач эрдэмтэн А.Д.Цендинагийн (Ц.Дамдинсүрэнгийн охин) судалж тогтоосноор Годан (Монголын ихэнх түүхийн номонд энэ нэрээр буй) хэмээх нэрийг онцолжээ. Гэвч монгол хэлэнд “үзэсгэлэн төгөлдөр” гэсэн утгаар Гоо хэмээх нэрийг эмэгтэй хүмүүнд, харин Хо гэдэг бол хүч чадал төгс гэсэн утгатай учир эрэгтэй хүмүүнд өгдөг нэр болохыг судлаачид анзаарна буй за. Хо-дан хэмээх нэр нь “дан цул хүч” гэсэн утга юм.

Судлаач Р.Ю.Почекаевын анзаарсан нэгэн зүйл нь, 1235 онд хаан эцэг Чингисийн даалгавраар Гүюг, Мөнх, Бат нар баруун зүг мордоход, дөнгөж 20 эргэм настай Ходан өөрийн цэргээ бие даан удирдаж одоогийн Хятадын баруун хойд нутаг руу дайлаар мордсон түүх юм. Чингис хаан түүнд ихээхэн итгэл найдвар хүлээлгэж байсан бөгөөд тэрээр нэн чадварлаг тулалдаж ялалт байгуулсан нь хаан эцгийнхээ байгуулсан төрийн хүчийг ихэд зузаатган дэмжих нөхцлийг бүрдүүлжээ. Чингис хаан амьд сэрүүн байхдаа Өгэдэйн дараа хаан ор суух хүн бол Ходан хэмээн цохон нэрлэж байсныг түүхэнд дурдсан (Рашид ад-Дин., Судрын чуулган. II боть 2002) байдаг нь түүний хэр хүч чадалтай хүн байсныг илтгэж байхад яагаад түүний талаар сүүл үеийн түүх бичлэгт нэн товч өгүүлдэг нь анхаарал татаж байна.

Ходан хааны аян дайны талаар «Юань ши», «Синь Юань ши»

хятад сурвалжуудад чухал мэдээлэл байгаа боловч уг мэдээллийг бичсэн хүмүүс тухайн үедээ Өгөөдэй хааны удмынхныг алдаршуулахаас зайлсхийж байсныг судлаач Р.Ю.Почекаев тэмдэглэжээ. Ямартай ч манай түүх бичлэгт тусгагдсан шиг Ходан хаан бол тухайн үедээ тийм ч үл анзаарагдам хүн биш, харин ч төрийн бие даасан хүчтэй бодлоготой удирдагч байсныг судлаач анзаарсан юм. Түүх бичлэг дэх хайнга хандлага нь харин ч түүнийг эсэргүүцэгчдийн тэр хэмжээний болгоомжлолын илэрхийлэл байж болох юм.

Үүнтэй холбоотой өөр нэгэн сэжиг бүхий мэдээлэл бол түүний нас барсан тухай мэдээлэл болно. Өгөөдэй хааныг нас барсны дараа түүний хатан Мэргид угсааны Дөрөгэнэ тухайн үеийн нөлөө бүхий ноёд, түшмэдтэй хамтран Далан даваанд хуралдаж хаан өргөмжлөх асуудал хэлэлцсэн боловч энэ явдлыг Өгөөдэй хааны ах дүү, үр сад, тэднийг дэмжигч язгууртнууд эсэргүүцэн, Хөх нуурын орчмыг захирч байсан Ходан хааны дэргэд тэдний олонх нь хуралдан бөөгнөрчээ. Ходан хааны өргөөнд Дөрөгэнэ хатны элч ирж Өгөөдэйн дотнын түшмэл, монгол гүрний баруун этгээдийн их сайд Чингай чинсан, лалын мөргөлт нөлөө бүхий түшмэл Мухамед Ялавач нарыг Дөрөгэнэ хатны мэдэлд өгөхийг шаардахад Ходан хаан: “Эднийг барьж өгвөл энэрэх сэтгэлийн хууль зүйд үл зохицохоос гадна хүний ёсноос гажуу хэрэг болно. Эднийг ураг удам, ноёд түшмэдийн өмнө аваачиж гэм буруугий нь тоочин хэлэлцүүлж зохих ялыг хүлээлгэе” (Жувейни М. 2006) гэж хэлүүлэн элчийг буцаажээ. Энэ бүхнээс үзэхэд, нэгдүгээрт, Чингис

хааны үр сад, ихэс сайд нар нь аливаа асуудлыг нийтээрээ шударгаар шүүн хэлэлцэж шийддэг байсан нь илт, хоёрдугаарт, Ходан хаан бол нэн шударга, энэрэнгүй, хүн чанарыг эрхэмлэдэг хаан байсан нь харагдаж байгаа бөгөөд чухам тиймээс ч Чингис хаан түүнийг хаан ширээнд залрах дараагийн хүнээр нэрлэсэн байж болох юм. Гэвч Дөрэгэнэ хатан болон түүний дотнын хамсаатан лалын шашинт Фатима гэдэг нэгэн эхнэр нар Ходан хааныг хорлож алахаар гарцаагүй байдалд оруулсан нь Ходан нас барахын өмнө өөрөө Фатимад хорлогдлоо гэж хэлж байснаас харагдаж байна (ШУА, Түүхийн хүрээлэн 2004, 169). Гэхдээ түүний нас барсан талаар үүнээс өөр тодорхой мэдээ байхгүй байгаа бөгөөд үнэхээр хорлогдож нас барсан уу, эсвэл аргагүйн эрхээр хорлогдсон хэмээн ташаа мэдээлэл өгч мөрөө буруулсан уу гэсэн асуултыг өөрийн эрхгүй төрүүлж байна. Ялангуяа судлаач Р.Ю.Почакаевын тэмдэглэн бичсэн “Дөрэгэнэ хатны гэнэтийн үхэл (1246 он) Ходаныг эсэргүүцэгчдийг сандаргасан бөгөөд... Фатимагийн хорлолоор бие өвдсөн хэмээх мэдээг Ходан тарааж, ...удалгүй түүнийг үхсэн тухай мэдээг ах Гүюг хаан нь хүлээж авч, ...Фатимаг цаазалсан (Ata Malik Juvaini. 1997. LXVIII, 764) ч, ...Ходан өөрөө тааварлашгүй байдлаар “амь орж”, удалгүй хөвүүдтэйгээ Монголд ирж шинэ хаан тодруулах хуралдайд оролцжээ (Ata Malik Juvaini. 1997. LXVIII, 249)” гэх мэдээлэл сонирхол татаж байна. Аливаа түүхэн үйл явдлыг цаасан дээр үлдээж хадгалдаг суурин соёл иргэншлийн уламжлалаас ялгаатай нь нүүдэлчин монголчууд балар эрт цагаас өвөг дээдэс болон байгаль орчлон, тэнгэр

газрын сүнс-сахиусыг бөөгийн биед дуудан ярилцаж, өмнөх домог түүхээ тодруулдаг уламжлалаар Ходан хааны сахиусыг дуудахад тэрээр нэн хожуу үе хүртэл амьд байж насан өндөр болтлоо төрийн үйл хэрэгт оролцож байснаа эргэн хүүрнэснийг энд дурдая (Төгсбаяр Г. 2022).

Ямартай ч Ходан хааны явуулсан Төвдийн Сажа хийдтэй, ялангуяа сажа лам Гунгаажалцантай хийсэн Монгол төрийн шашны бодлогыг энд дурдахгүй өнгөрүүлж болохгүй. Монгол хаад, тэр цагтаа Буддын шашны гол орон болж байсан Түвэдийг шууд цэрэг зэвсгийн хүчээр эзлэн авах замаар бус харин “Тахилын лам, Өглөгийн эзэн хоёрын барилдлага” тогтоох аргаар эрх мэдэлдээ оруулан авах бодлогыг явуулж байжээ. “Тэд Төвөд дэх Буддын шашныг эзлэгдсэн орныг дарангуйлан захирах үзэл онолынхоо гол зэвсэг болгож ашиглахыг эрхэм болгож байлаа” (ШУА, Түүхийн хүрээлэн 2004, 321) хэмээн түүхчид тодорхойлсон байдаг ч үнэн хэрэгтээ *шашныг хүмүүний сэтгэлийн дотоод нандин зүйл гэдэг талаас нь харж, “сэтгэлийг нь эзэмдвэл бие нь хаа холдох” хэмээх Чингис хааны гүн ухаанд тулгуурлан Ходан хаан төрийн бодлогоо боловсруулж байсныг* онцлох нь зүй юм.

Тиймээс ч Төвдийг дайлаар мордсон Ходан хаан 1244 онд Саж хийдийн их хамба Гунгаажалцанд (1182-1251) заллагын бичиг илгээж, улмаар 1247 онд Ходан хаан, сажа лам Гунгаажалцан нар Лань-чжоуд уулзаж “Тахилын лам, Өглөгийн эзний” барилдлага анх тогтоосон байна. Сажийн хамба бээр Ходан ноёны ордноос түвэдийн лам нар болон түвэд

хүмүүст илгээсэн бичигт: “...*Би хүний номоор, чибурханы номоортэтгэгдвээс Шагжамунийн шашин гадаад далайн тэртээ хүртэл түгэхгүй гэж үү? ...Чи тайван байж ном номно, чамд аль хэрэгтэй бүхнийг би өгнө, чамайг сайн болгохыг би мэднэ, намайг сайн болгохыг тэнгэр мэднэ. ...Чи өөрийн хүн аймаг түвэд нарыг ёс журамтай сайтар сурга, Харин тэднийг жаргалд оруулахыг би мэдье*”^{5*} (Агваангунгаасодномдагважалцан 1630, 78-81) гэх зэргээр Ходан хаан Гунгаажалцанд өгүүлж байсан тухай дурджээ. Энд төр, шашин хоёр тусдаа өөр өөрийн үүрэгтэй болохыг заагаад, гагцхүү төр, шашин хоёр хамтран зүтгэвэл аль алины хэрэг бүтнэ гэсэн санааг илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл шашин нь ард олныг хүмүүжүүлэх үүрэгтэй бол, төр нь ард олны амар амгалан байдлыг хариуцдаг болохыг тэмдэглэжээ. Мөнхүү бичигт, Гунгаажалцан нь монголчуудад үг дуугүй захирагдах, Монголын хааны Алтан гэрэгэт элч нарыг аль болох хүндэтгэн хүлээн авч байх зэргийг өөрийн орны хүмүүст ятган ухуулсан байна. Үүний зэрэгцээгээр Гунгаажалцан нь монгол цэрэг тоо томшгүй олон бөгөөд бүх замбуулин Монголын хааны эрхэнд байгаа мэт санагдахаар байна, монголчууд бол өөртөө захирагдсан бүхэнтэй жаргал зовлонгоо хуваалцаж, өөрийн нь эсэргүүцсэн, өөрт нь үл захирагдсан бүхнийг бут цохин дардаг зэргийн тухай уул бичигт бичсэн ажгуу. Түвэд орон ямар ч арга заль хэрэглэлээ гэсэн газар нутгийн хувьд хэчнээн хол байлаа ч гэсэн хүчирхэг байлдан

дагуулагчдын аюулаас зайлсхийх нөхцөл байхгүй гэдгийг Гунгаажалцан өөрийн орны хүмүүст үнэмшүүлэхийг их чармайсан нь уул бичгээс тодорхой байна. Монголчуудад сүйтгэгдэхгүйн ганц арга бол тэднийг үг дуугүй, ямар ч эсэргүүцэлгүйгээр дагах явдал мөн бөгөөд ийм учраас монголчуудын юу шаардсан бүхний нь биелүүлж байхыг мөнхүү бичигт заажээ. Бичгийн эцэст монголын хаадад чухам ямар бэлэг өргөж байхыг хүртэл тогтоожээ. Уул бичигт, Түвэдийн муж тус бүрийн хүн амын тоо, мужийн ноёны нэр, албан гувчуурын хэмжээг тодорхойлсон бичгийг гурван хувь үйлдэж, нэгийг нь Гунгаажалцанд илгээж, хоёрдахыг нь Саж хийдэд өгч, гуравдахийг нь мужуудын ноёдод байлгах хэрэгтэй гэж шаардсанаас гадна монголын хааныг үл дагагсдаасаа болж бут цохигдож болно гэж Гунгаажалцан өөрийн бичигт анхааруулжээ (ШУА, Түүхийн хүрээлэн 2004, 323). Энэ бүхнээс Ходан хаан ба Саж лам Гунгаажалцан хоёрын харилцаанд Ходан хааны давуу байдлаа хадгалж, өөрөөр хэлбэл *төр, шашны харилцаанд төр нь давуу эрхтэй, гэхдээ шашныг хүндэтгэж дэмжих замаар ард олны сэтгэлийг татах бодлого явуулж байсан* нь тодорхой байна.

Үүний дараа нь Хубилай хаан 1253 оны орчим Ходан хааны бодлогыг үргэлжлүүлэн, Түвэдийн Саж хийдтэй холбоо тогтоохоор Ходан хааны ордон руу элч зарж Сажийн хамба Гунгаажалцанг залжээ. Гэвч Гунгаажалцан 1251 онд нас барсан байсан тул Ходан хаан түүний ач, Пагва лам Лодойжалцанг (1235-1280)

^{5*} Лань-чжоу хотоос Түвэдийн лам хар хүмүүс Гунгаажалцаны илгээсэн бичиг Сажийн хамба нарын бүрэн зохиолын эмхэтгэл (Саж кан-бум) “на” боть 214-217;

толилуулав. 1247 онд Ходан хаанд бараалхахдаа Гунгаажалцан 9 настай Пагва Лодойжалцан, түүний дүү Чагнаадорж нарыг дагуулан иржээ. Ходан хаан тэр хоёр хүүг ирээдүйд Түвэдийг захирах өөрсдийн нөлөөний хүмүүс болгон хүмүүжүүлж өсгөсөн нь Чингис хаан үрчилсэн хөвүүдээ өөрийн шадар сайд болгон Өүлэн эхээрээ өсгөж хүмүүжүүлсэнтэй ижил бодлогыг хэрэгжүүлсэн хэрэг юм. Хубилай хаан 1253 онд Пагвыг 18 настай байхад нь Дээд нийслэл (Шанду) дэх ордондоо залж өөрийн тахилын лам болгон, Буддын шашны нэр хүндийг ашиглан Түвэдийг өөрийн эрх мэдэлд оруулсан билээ. Пагва лам мөн л Хубилай хааны даалгавраар Түвэдийн лам хуврагуудад хандан захиа бичиг илгээж ямар ч үг яриа эсэргүүцэл гаргахгүйгээр Монголын хаанд захирагдах, гагцхүү бурхан шашны үйл хэргээ эрхэмлэн ном бясалгаж суухыг уриалжээ. 1264 онд Шан-ду хотод бичсэн Хубилай хааны “Сувдан зарлиг” (Агваангунгаасодномдагважалцан 1630, 94-96) дотор Монголын хаанаас Түвэдийн талаар болон Буддын шашны талаар явуулж байсан бодлогыг тодорхой өгүүлсэн буй. Энэ бичигт улсын багшийн тамгыг Пагва ламд өргөн, түүнийг нийт Түвэдийн шашны тэргүүнээр өргөмжлөн, нэг үгээр, шашнаар дамжуулан Түвэдийн ард олны сэтгэлийг эзэмдсэн байна. Монголын хаанд дуулгавартай захирагдан гагцхүү шашин ламын ёсоор явагч лам нарыг улаа, алба гувчуураас бүрэн чөлөөлөх, сүм хийдэд элч буух, сүм хийдийн харъяаны газар ус, эд хөрөнгийг эдэлж эзэмшихийг мөн хагуу хориглосон тухай уул бичигт дурдсан байна. Энэ зарлиг болон

бас бус зарлигуудаас үзэхэд бурханы шашин Монголын эзэнт гүрний дотор онцгой байр суурьтай болсон нь “шашнаар сэтгэлийг эзэмдэх” Монгол төрийн бодлогын илэрхийлэл байв.

“Арван буянт номын Цагаан түүх”-нд: “Номын засаг үгүй бөгөөс амьтан унаюу, хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдэрьюу. ...Дээд шашны үндсэн номын эзэн лам ба Төрийн эрхин ертөнцийн эрхэт хаан хийгээдийн үнэн номын засаг хэвийн зангиа мэт мэт алдаршгүй, хааны засаг алтан буулга мэт эвдэршгүй” байна хэмээсэн нь Хубилай хаанаас “Төр ба Шашин номын хоёр ёсон” буюу төр, шашныг хослон барих бодлогоо тодорхойлсон хэрэг юм.

Эрдэмтэн түүхч Ч.Далай Хубилай хааны шашны бодлогыг тодорхойлж: “Монгол хаад бурхны шашныг гүрний гол шашин болгосон явдал нь хэдийгээр хятадад уусан хайлахаас болгоомжилсон тал байсан боловч хамгийн гол нь янз бүрийн шашин шүтдэг, соёлтой олон хэлтэн улс, аймгуудыг төрийн нэг шашнаар нэгтгэж захиран ноёрхох гэсэн улс төрийн бодлогоос үүсэн гарчээ” (Далай Ч. 1992, 163) хэмээчихүй.

“Цагаан түүхийг” Хубилай хааны айлдсан “Сувдан зарлиг”-ийн эмхэтгэл ч гэдэг бөгөөд “Сувдан зарлиг” нь Ходан хааны дэргэд номын зөвлөхөөр 5 жил ажилласан Сажа лам Гунгаажалцаны бичсэн гэгддэг (гэхдээ Ходан хааны айлдвар зарлиг байх магадлалтай) “Эрдэнийн сан Субашид” (“Сувад-шид” гэсэн монгол нэр байх магадлалтай)-аас санаа авсан бичвэр гэж үзэж болно. Үүнд зөвхөн шашны асуудал төдийгүй, аливаа асуудлыг шийдвэрлэхэд баримтлах

Монгол төрийн ерөнхий бодлогыг нарийн сайтар айлдсан байдаг. Чухам төрийн ерөнхий бодлогоос л шашны бодлого урган гарна. Өөрөөр хэлбэл,

Хубилай хааны шашны бодлогын гүн ухаан нь Ходан хааны бодлогод ал эрт тусгагдсан байсан гэж хэлж болно. Тухайлбал Сувад-шидэд өгүүлснээр:

Нэг. Төрийн зөв бодлогыг сонгож хэрэглэх тухайд.

VI-201

Агуу сайн ухаантан болоод шударга төвшин ноёд
Албат иргэн ба төрийн хэргийг онож шийтгэюү
Адилтгавал сайн сумаар мэргэн харваач харвабал
Аль зорьсноо алдалгүй онох мэт

Хоёр. Албат иргэдээ асран хамгаалах тухайд.

IV-141

Агуу ухаант сайн ноёд дайсантай учирвал
Албан иргэнээ улам ихэд хайрлаюү
Адилтгавал өвдсөн хөвүүнээ эх нь
Асар ихэд энэлэн хайрлах мэт

Гурав. Бусдын үгийг сонсож асуудлыг шийдэх тухайд.

VIII-304

Ухаант хүн өчүүхэн бага хэргийг ч
Олон нөхөдтэйгээ зөвлөж үйлдьюү
Урагштай сайн бүтвал ер юун өгүүлэх
Огоот эс бүтэвч зэмлэлгүй амар больюү

I-30

Өчүүхэн хүүхэд хэлсэн боловч сайн үг мөн болбол
Үнэн ухаантай мэргэд нь түүнийг тогтоон авна
Үнэр сайт заарыг хэрэглэн дурласан хүн
Өмхий хүдрийн хүйснээс ч жигшилгүй авах мэт

Дөрөв. Ялгаваргүй тэгш хандах тухайд.

IV-114

Ашид энэ нь амраг, энэ нь өстөн гэж
Алимад өчүүхэн бодлоготон өөр өөр ялгана за
Агуу ухаантан дээдэс нийтийг асарсанаар
Аль хэн ч бөгөөс түүнд тус хүргэюү

Тав. Зөв аргыг хэрэглэх тухайд

VIII-313

Урин санаагаар хорлогч дайсныг ч
Уран аргаар бөхийлган чадвал нөхөр болох бий
Огоот бие аминд хорлох их хорыг ч
Учры нь мэдэж найруулбал эм болох мэт

VI-305

Амьтны санаа дур элдэв зүйл тул

Ашид бүхний ойнд орох ер бэрх
Алимад олон зүйл эрдэмтэй болоод зөв явбал
Ард олонхын сэтгэл түүнд дурших бий.

Зургаа. Алба татварын бодлого

VIII-324

Тэргүүлэгч ихэс ноёд олонд хор үл болохыг
Тэгш хэрээр бодож татвар албыг бүтээтүгэй
Тэр нь сал модны шимийг хужинд хольвол сайн болох боловч
Түүнийг нэн их авбал мод нь хатаж одохтой адил

Долоо. Хатуу зөөлөн аргыг хослон хэрэглэхийн тухайд

VI-200

Зөрчин харшилсан хүнийг хорлон чадагч хүн
Зөөлөн шударга ханилсан нөхөртөө тусалж чадах
Зүггүй буруу явагчдыг засаглаж алан чадагч хаан
Зөв зохистой явагчдыг дэвшүүлэн зэрэг өгч чадьюу

VIII-385

Өвөр ба бусдын тусыг бүтээхэд
Өчүүхэн зөөлөн ширүүн ямар мэт загнавч
Үнэхээр мэргэн аргаар үйлдэх явдлыг
Өөдгүй хуурмаг мэх гэж бурхан эс номлолоо

Монголын эзэнт гүрний үеийн дээрх төрийн бодлогын хүмүүнлэг зарчмууд нь шашны асуудалд хандах хандлагыг ч мөн адил тодорхойлж байсан юм.

Шашны тал дээр “ард олны сэтгэлийг эзэмдэх бодлогыг” Монголын их эзэнт гүрний бусад газарт ч, тухайлбал Алтан ордны улс, Цагаадайн улсад ч Христийн болон Исламын шашнаар дамжуулан тухай тухайн орны ард түмний сэтгэлийг өөртөө татахад хэрэглэсээр байв. Гагцхүү эзэнт гүрний үеийн шашны бодлогод хоёр зүйл алдаа гарсан нь, нэгд, шашинд хэт хүндэтгэлтэй хандсанаар өөрсдөө тухайн шашны нөлөөнд автагдсан (жишээ нь Цагаадайн болон Алтан ордны улсад), хоёрт, нэг шашныг бусдаас нь хэт дөвийлгөн тэтгэснээр бусад шашинтнуудын зүгээс дургүйцэл

төрүүлж, эсэргүүцэл тэмцэл гарах шалтгаан болсон байна (жишээ нь Юань гүрэн).

Монголын эзэнт гүрэн задарснаас хойш Монгол газраа бөө мөргөл шүтлэг эргэн сэргэсэн боловч их хаадын “Мөнх тэнгэр шүтлэг”-ээс ялгаатай нь асуудалд гүн ухааны үүднээс гэхээсээ илүү зан үйлийн түвшинд хандаж, тайлга өргөл өргөх явдал ихсэж, аажимдаа тэр нь шашны хатуу тахилга засал болж хувирсан ажээ.

Монголын эзэнт гүрний бутралын үе буюу XIV-XVI зуунд балар эрт үеэс уламжилсан бөө мөргөл, тэнгэр шүтлэг Монголын нийт ард түмний дотор урьдын адил шүтэгдсээр байсан ч энэ шүтлэгийг Монголын бага хаад Бурханы шашинаар бүрмөсөн солих оролдлогыг хийж эхэлсэн юм.

Бутралын үеийн бага хаад Монгол, Төвд, Хятадыг нэгтгэж, Их Юань

гүрнийг байгуулан, билиг ухаанаар засан тохинуулж чадсан Хубилай сэцэн хааны улс төрийн бодлогын нэгэн гол хүчин чадал нь Энэтхэг, Төвдөөс уламжилсан Бурханы Очирт хөлгөний шашин мөн гэдэгт итгэж, Хубилай хааны үлгэр жишээгээр Их Монгол улсаа дахин мандуулахыг зүйл бүрээр оролдож эхэлсний дотор төр, шашныг хослон барих аргыг эрэлхийлж байв.

Бөө мөргөлийг халах Алтан ханы цааз хуулийн талаар Өвөр Монголын түүхч эрдэмтэн Т.Мансан бичихдээ: “XVI зууны сүүлээр Түмэдийн Алтан хан шарын шашныг ашиглаж, ард түмний уур хилэнг нь намжаахын төлөө, цаашилбал шарын шашны дэмжлэгээр халхын ноёдыг захирах эзэрхэг эрхийг тэмцэн авахын тулд нэгэнт хүндээ барсан бөөгийн шашныг хүчингүй болгож, шарын шашныг дэмжин дэлгэрүүлэх тухай хууль зарлиг нийтэлж байв.

Тэр хууль зарлалын чухал зүйлд:

1. Монгол даяар шарын шашны арван буяны зарчимд байх хэрэгтэй.
2. Үхэгсдийн араас мал амьтан алж тахилга хийж болохгүй. гурван цагаан (сүү, ээзгий, айраг)-ы тахилаар тахих хэрэгтэй.
3. Лам хуврагийн ёсоор явах хүнийг цохиж барьж болохгүй.
4. Бөөгийн онгон хөргийг галдан шатааж, түүний оронд бурханы хөргийг тахих
5. Булаан дээрэмдэхийг огт үйлдэж болохгүй зэрэг агуулгатай” (Мансан Т. 2004, 234) хэмээх мэдээллийг өгчээ.

Алтан ханы хууль цаазын тухайд, Монгол улсын түүхийн 3-р ботид уг хуулийг алдарт түүхч Саган сэцэний

элэнц өвөг хутагтай Сэцэн хунтайж зохиосон бөгөөд тэрээр уг хуулийг зохиохдоо “Хубилай хааны үед зохиосон “Арван буянт номын цагаан түүх”-ийг ашигласан байна” хэмээсэн буй.

Харин XVI зууны үеийн Төвд дэх шашин хоорондын мөргөлдөөний талаар түүхч эрдэмтэн Л.Тэрбиш тайлбарлахдаа: “Богд Зонхавагийн төрсөн газар Гүнбүм хэмээх хийдийг байгуулснаас хойш шар малгайтны шашин Хөх нуур орчим улам хүчтэй дэлгэрэн XVI зууны дунд үеэс ойрад Монголд шарын шашин хүчтэй дэлгэрч эхлэв. Шарын шашин ийнхүү хүчтэй дэлгэрсэн нь бурханы шашины бусад урсгалуудын эрх ашигт нөлөөлжээ. Иймээс бусад урсгалын тэмцэл зөрчилт шар малгайтны шашин өртөгдөх болов. Бас эдгээр урсгалыг хуучин үеэ өнгөрөөсөн бөөгийн шашнууд овжиноор ашиглах болов” (Тэрбиш Л. 2008, 117) хэмээн тухайн үеийн шашны урсгалуудын тэмцэл хурцадсан нөхцөлд Монголд шарын шашныг хүчтэй дэлгэрүүлсэн түүхэн үйл явдлыг тэмдэглэн бичжээ. Мөн түүхч эрдэмтэн Д.Дашбадрах “Алтан ханы үйл ажиллагааг эсэргүүцэх явдал Өмнөд Монголд хүртэл гарч байжээ. Арван хоёр түмэдийн ноёд үг өгүүлэл гаргаж байсан учир Хутагт сэцэн хунтайж, Манзушири хутагтын хамт тэднийг сүхдүүлэн аймшуулахын зэрэгцээ шашин номын “ач тус”-ыг олонтаа номлон “эс ухсан олныг сөгөөж”, хойшид шашин хийгээд лам хувраг нарт гэм хийхгүй байх, шашныг дэлгэрүүлэх ам авч, хууль цааз нэмэн баталсан нь үнэн хэрэгтээ Өмнөд Монголд гэлүгбагийн шашныг албан ёсоор зөвшөөрүүлэн хүлээлгэсэн хэрэг” (Дашбадрах Д. 2012, 111) хэмээчихүй. Өөрөөр хэлэхүл, нэг

шашныг нөгөөгөөр албадан солих, хүчээр даран устгах, шашныг ялгаварлан үзэх аливаа оролдлого нь зөрчил тэмцэлд хүргэх сөрөг талтай ажгуу.

Энд жич дурдахад, орчин үеийн шашин судлал, ялангуяа шашны сэтгэл судлаачдын судалгаагаар, аливаа шашныг сүсэглэгчдийн хувьд тухайн шашин шүтлэг нь тэдний сэтгэл санаанд гүн нарийн, ариун нандин дадал зуршил болсон байдаг бөгөөд үүнийг тэр бүр ухуулга сурталчилгаа, тайлбар номлолын аргаар өөрчлөх боломжгүй тул хүн төрөлхтөний түүхэнд нэг шашнаас нөгөө шашинд шилжих үйл явц ихэвчлэн хүч хэрэглэхэд хүргэсэн, үүний улмаас хуучин шашин сүслэгчид нь эсвэл сүсэг бишрэлээ сэтгэлийн гүндээ нуун далдлах, эсвэл шинэ шашны өнгө аясыг гаднаа хэлбэр төдий дагалдахад хүрдэг гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Хубилай хааны үед Төвд, Монголын бурханы шашины дотор нэр хүндтэй байсан Сажийн ёс XVI-XVII зуунд Гелүгбын ёсоор солигдох үйл явц нь тийм ч амар хялбар замаар шийдэгдээгүйг судлаачид тэмдэглэсээр байна.

Түүхийн ухааны доктор Л.Тэрбишийн “Ойрадын бурхан шашины товч түүх” номонд өгүүлснээр, “Ойрадад шарын шашин тодорхой хэмжээгээр нэвтэрч, ...ойрадуудад ихэд хүндлэгдэн тахигдах болсон Цагаан номын хаан Манзушри хутагт Жалбажамц, Жэдшод хувилгаан зэрэг лам нар нааш цааш явж ном дэлгэрүүлэх, номын цагаан үйлсээр ардыг тэтгэх, сахил санваар хүртээх зэргээр шашинд ачлал үзүүлж байв. Түмэдийн Алтан хааны үеэс түүний үр сад Хөх нуурыг захиран сууж ахуй

энэ үед Халхад улааны хийгээд шарын шашинтны хооронд маргаан болж, Цоохор Цогт Хөх нуурыг уулгалан дайраад Холочи ноёныг ялж, Цогт хаан хэмээн нэр авч эзэгнэн суугаад шарын шашны хуврагуудыг барьж шоронд хорих зэргээр шашинд хорлол үзүүлж, мөн Төвдийн Вэри Доёддорж, Замба хаан нартай нууц холбоо тогтоож, улмаар Богд Зонхавагийн шашин соёлыг устгахаар бэлдээд байв... Гармава, Гаржүдвийн урсгалынхан шарын шашинтай хүчтэй тэмцэлдэж, ... Замба хааны залгамж бүр шарын шашинд сөрөг нөлөө үзүүдэг муу уламжлал тогтжээ... Төвдийн Хам орны хаан Вэри Доёддорж, Төвдийн ном дэлгэрсэн гол орны Замба дэсрид, Цогт тайж нар бүлэглэл байгуулж, Улааны шашныг дэлгэрүүлнэ гэсэн нэрийн доор Богд Зонхавагийн шашныг устгаж, үеэ өнгөрөөсөн бөөгийн шашин хийгээд даосын шашныг тогтоохоор заналхийлсэн эгзэгтэй үед Төрбайх ноён шар малгайтны шашныг өмөглөн тусалж, шашин соёлыг нь хамгаалсан” (Тэрбиш Л. 2008, 99-100, 160) хэмээчихүй. Энд жич хэлэхэд, доктор Д.Будсүрэн “Цогт хун тайжид холбогдох түүхэн баримтын судалгаа” бүтээлдээ зөвхөн шарын шашны талыг барьсан судлаачид Цогт хун тайжийг буруутгасан тайлбар өгдөг хэмээн тэмдэглэсэн байна. Гэхдээ ихэнх судлаачдын үзэж байгаагаар тухайн үеийн монголчууд үнэхээр улааны ба шарын шашин хэмээн хоёр хэсэг болж талцан, өөр хоорондоо шашны төлөө цуст тэмцэлд хүрсэн бус аа.

Монголын түүхийн гутгаар ботид тэмдэглэснээр, “Түмэн засагт хаан, Халхын Автай сайн хан, Түшээт хан Гомбодорж, бүх Монголын сүүлчийн их хаан Лигдэн, Цогт хун тайж тэргүүтэй талын зонхилох сурвалжит

язгууртнууд Алтан хан лугаа зэрэг шахам өөр хоорондоо уралдах мэтээр бурханы шашинд даган орж баримтлах болсон явдал юм” (ШУА, Түүхийн хүрээлэ 2005, 363). XVII зуунд Төвдөд Шарын шашны дайсан хэмээн үзэгдэж байсан Лигдэн хаан, Цогт хун тайж нар бурханы шашны оюуны их соёлын дурсгалыг монгол түмэндээ үлдээсэн Монгол ухаант төрийн зүтгэлтнүүд гэдгийг түүхч, утга зохиол судлаач, шашин судлаач, улс төр судлаачид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал судлаач доктор Д.Будсүрэнгийн үзсэнээр: “XVII зууны үеийн Монгол оронд Төвдийн шашны хоёр урсгал нь илэрхий зөрчилгүйгээр дэлгэрч, бурхан багшийн шашин хэмээх утга санаанд багтаж байсан тул Гелүмба-гийн шашны болон Гарма гаржүмба-гийн шашны сүм хийд буюу тэр чиглэлийн лам хувраг, хутагт хувилгаад хэмээн онцлон ялгасан зүйл байгаагүй болох нь Цогт хун тайжийн зарим үйл явдлаас тодорхой харагдаж байна. Цогт хун тайжийн өөрөө зохиосон болон тухайлан үйлдүүлсэн хөшөө чулууны бичээсээс үзэхэд Гарма гаржүмба-гийн тогтсон тааллын ёсыг баримталдаг болох нь тодорхой атал, тухайн үеийн Гелүмба-гийн шашны томоохон зүтгэлтэн нэрт дуун хөрвүүлэгч Гүүш цоржтой дотно харьцаатай байсныг дурдаж болно. Иймд, Цогт хун тайжийг шарын шашны эсрэг, улааны шашныг хамгаалан тэмцэгч байсан мэтээр өгүүлэх нь түүхийн бодит байдалд төдийлөн нийцэхгүй бөгөөд Цогт хун тайжийн улс төрийн үйл хэрэг, цэрэг дайны явдлыг нь тухайн цаг үеийн нийт монголчуудын ороо бусгаа байр байдалд нь авч үзэх ёстой... Төвд, монгол хэлээр бүтээсэн гэрэлт хөшөөний бичээст гарах бурхадын

алдар болон тарнийн зүйлийг тодлон үзвэл, яах аргагүй Гарма гаржүмба-гийн тогтсон тааллын ёсны догшид бурхадыг ядам болгон шүтдэг болох нь илэрхий мэдэгдэж байна” (Будсүрэн Д. 2011, 138) хэмээчихүй.

Лигдэн хааны хувьд ч мөн адил “бүх Монголыг “тайван төрөөр” буюу эв эээр нэгтгэхэд чиглэсэн төрийн бодлогодоо бурханы шашныг ашиглаж, чингэхдээ шарын хийгээд улааны урсгалыг мөн л адил тэгш дэмжиж, бүх Монголыг эв эээр нэгтгэн захирах бодлого” (Дашбадрах Д. 2012, 113) баримталсан хэмээн судлаач эрдэмтэн Д.Дашбадрах өгүүлчихүй.

Цогт хун тайжтай адил нөхцөл байдал Өндөр гэгээн болон Галдан бошигтын үйл ажиллагаанд ч тулгарсан гэж хэлж болно. Монголын эрдэмт хутагтуудын сурч боловсрох газар нь нэгэнт Шарын шашны гүн ухааны дацан сургуулиуд болж, мөн хутагт хувилгаад тодруулахыг Банчин-Эрдэнэ, Далай лам нараас зөвшөөрөл авдаг ёс нэгэнт Монголд тогтож хэвшсэний дагуу Өндөр гэгээнийг “Гэтэлгэгч Богд ойн Даранатын хувилгаан биеийг бодтой барьсан” хэмээн эш үзүүлсэн боловч сүүлдээ Жонанбагийн ёсноос Гелүмбагийн ёсонд татан оруулах бүх талын оролдогыг хийсэн тухай олон судлаачид дурдсан бий. Бурханы номын мөр хөөж Цастын орныг зорьсон 1906-1907 онуудад Тангудын Лавран хийдэд сууж агсан Буриадын судлаач Базар Барадин тэмдэглэлдээ Жонанбагийн урсгалд хүчтэй нөлөө үзүүлсэн Долбупба Шерав Жалцан-гийн тухай өгүүлсэн байх бөгөөд төрөлхтөн бүхэн зүрхэндээ бурханы дүрийг агуулж байдаг гэсэн Долбупбагийн үзлийг үндэслэлгүй хэмээн Гелүмба тэргүүтэй

бусад урсгалууд шүүмжилдэг ч, хэн ч няцааж чаддаггүй байсан тухай дурджээ. Түүний үйл хэргийг Таранат (1595) гэгээн улам хүчтэй үргэлжлүүлсэн бөгөөд Таранатын дараагийн хувилгаан дүр нь Өндөр гэгээн байж Гелүмба ёсонд орсноор энэхүү Жонанбагийн урсгал үгүй болсон тухай энэхүү тэмдэглэлдээ өгүүлсэн буй (Базар Барадин. 2002, 43-44). Өндөр гэгээний урлаг соёлын бүтээлүүдийн үзэл санааг дээрхи Долбунпбагийн үзлээр тайлбарлаж болмоор санагдаж байна.

Харин Галдан бошигтын тухайд, түүхч эрдэмтэн Д.Дашбадрахын бичсэнээр: “Дэсрид Санжаажамцын явуулгаар Галдан бошигт Далай ламын төлөөлөгч Галдан ширээтэй нэгэн зиндаанд суусан гэдгээр шалтаглан Хүрэнбэлчирийн чуулганы үзэл санааг Галдан бошигт бусниулан, Халх-Ойрадын хямралыг даамжруулан, улмаар Халхад цэрэглэн довтолсоныг бид мэдэх билээ”. Энэ талаар төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар докторын судалгаанд илүү тодорхой өгүүлсэн буй: “Төвдийн Зонхавын шарын шашны төлөөнөөс Галдан бошгот зэвсэг өргөн босож, урд урьд түүхэндээ улааны шашны гэгдэж байсан халхын сүм хийдүүдийг түймэрдэн, Өндөр гэгээнийг уулгалж, түүний учраа Халхын Өндөр гэгээн нар тусгаар байдалдаа хамгааллыг эрэн Манж эзнийг түшиж орсон нэгэн хэргийн үндэс тодорч байна. Галданыг ...Зонхавын шашны төлөө гэдэг нэрийн дор бурханаас “эш бошготой” элч болгож, зэвсгий нь бариулан дөрвөн Ойрад руу илгээсэн хүн бол төвдийн төрийн сайд дэсрид Санжаажамц юм” (Хүрэлбаатар Л. 1996, 29) хэмээсэн буй. Гэвч Галдан бошготын үйл хэргийг буруутгахаасаа зөвтгөх

хандлага сүүлийн үед судлаачдын дунд элбэг болж байгааг мөн тэмдэглэе. Тухайлбал, өвөр Монголын судлаач эрдэмтэн Өлзийгийн бичсэн “Монгол хаад” цувралын “Зүүн гарын хаант улсын хаад” хэсэгт өгүүлснээр “Галдан Халхыг Манжид шахан оруулна гэж огт бодоогүй. Цэргийн хүчээр давах учир Халхыг өөртөө оруулж чадна гэмээн тооцоолж довтлон орсон бөгөөд Түшээт хан Чахуундорж ч Галданаас зугтааж Манжийн нутагт орохдоо дагаж орохыг бодсонгүй нь лавтай. манжаас цэрэг зэвсгийн тусламж олж, эргэж Галдантай тэмцэнэ гэж тооцоолсон нь аль алиных нь арга бодлогын алдаа байв. Энэ хоёр хүний аль алиных нь энэ бодлого нь хэргийн явц Монгол улсын тусгаар тогтнолд ноцтой хохирол учруулахад хүргэсэн нь хожмын хэрэг явдлуудаас илэрхий болсон юм” (Тү.Өлзий. 2010) хэмээчихүй.

XVI-XVII зууны үед монголчуудын шашинд хандах хандлага нь: нэгд, Монголын нийт олон түмний шүтээн болж байсан бөө мөргөлийг хааж бурханы шашныг дэлгэрүүлэх, хоёрт, Монголын хаад язгууртнуудын нийгэм-улс төрийн үйл ажиллагааны удирдлага болж байсан улааны шашны байр сууринд шарын шашныг гаргах, гуравт, бурханы шашны ертөнцийг үзэх үзлийг урлаг соёл, утга зохиол, түүх, гүн ухаан гээд Монголын оюуны соёлын бүхий л хүрээнд үнэт зүйлээ болгон дээдлэх гурван чиглэлээр өөрчлөгдөн шинэчлэгдэж байсан бөгөөд эртний сурвалжууд ч, өнөөгийн судлаачдын байр суурь ч дээрхи гурван чиглэл бүхний доторх ялгаатай, зарим тохиолдолд эсрэг тэсрэг хандлагуудын аль нэг талыг барьсан буюу дэмжсэн, эсвэл дундыг барьсан тайлбаруудыг өгч байна. Энэ

нь судалгааны ялгаа зөрчилтэй, нэг мөр бус дүгнэлтүүдийг бий болгож байгаа бөгөөд энэхүү ээдрээтэй үеийн тодорхойгүй үлдсэн олон асуудлыг шийдвэрлэхэд олон талын мэргэжлийн судалгааг шашин судлалын үүднээс нэгтгэх шаардлагатай байна.

XVII зуунаас эхлэн Түвэдийн гелүгбийн буюу шарын шашин нийт монголчуудын шашин шүтлэг болж хувирсан бөгөөд Түвэд дэх төрийн бодлого ба шарын шашны харилцан хамаарлыг доктор О.Чимэг дүгнэн хэлэхдээ: “Түвэдийн феодалын бутрал, түүний илрэл болж байсан Бурханы шашины олон урсгал чиглэлийн тэмцлийг эцэс болгоход чиглэсэн Зонхав богдын “шинэчлэл” нь Буддын шашины өвөрмөц онцлог бүхий урсгал чиглэлийг төрүүлсэн төдийгүй, түүнийг нийгмийн “төрийн” философи болгоход тулгуур болжээ. Түүний “Бодь мөрийн зэрэг” зохиол дахь “шашин бүхнийг харшил үгүйд онохын гайхамшиг” их, бага, очирт хөлгөнийг нэгэн зам мөрийн үе гишүүд болгож, энэ замаар дэс дараалан хөтлөх багшийг шүтэх, ингэхдээ “үнэмлэхүй үнэн” гэгдэх Бурханы шашиныг “цаазаас хэтрүүлэлгүй” баримтлах тухай үзэл санаа нь гэлүгба чиглэлийг Түвэдийн бус бүх чиглэлийн “хураангуйлсан” ганц үзэл суртал болтлоо хөгжиж, шашины тэргүүн Далай лам нарын шашин, төрийг хослон барьсан теократ засаглал тогтох онолын үндэс болсон байна. Багшийг шүтэх ёс нь феодалын байгууллын зэрэг дэвийг үзэл суртлын “зэрэг дэвээр”, угсаа залгамжлалыг үзэл санааны залгамжлалаар солих, теократ засаглал тогтох онолын үндэс болсон бөгөөд сүм хийдийн зан үйл, дэг ёсонд түүний хийсэн “шинэчлэл” энэхүү засаглалын үлгэр

загвар болжээ. Түвэдийн нийгмийн хувьд энэ нь хутагт хувилгаадыг тодруулах үйл ажиллагаагаар илрэх болсон. Надаас хойш миний хоёр шавь эргэж төрнө гэж Зонхава богд эш үзүүлэн хэлсэн хэмээх үгийг хожтоо Далай лам, Банчен эрдэнийн олон дүрийг тодруулах үндэслэл болгожээ. Хутагт хувилгаад тодруулах үйл ажиллагаа чухам Түвэдэд гарч ирсэн нь санамсаргүй зүйл биш байв. энэ нь феодалын эзэн харъяатын ёсыг үзэл санааны харъяалал болгон ыэхжүүлж, үндэсний тусгаар тогтнолоо хамгаалах зорилготой байжээ. ийнхүү Түвэдийн тулгар төр байгуулагдах үеийн хэмжээгүй эрхт хаант засаг нэг үзэл суртлын хаанчлалаар, шинэ газар нутгийг хүчирхийлэн эзлэх явдал оюун санааны эзэмшлийг өргөжүүлж “үзэл санааны орон зай” эзлэх тэмцлээр тус тус солигджээ” (Чимэг О. 2001, 105-106) хэмээчихүй.

Харин Монголын хувьд, XVI-XVII зуунаас монголчуудын олон зуун жилийн дотоодын хямрал, бутралыг даван туулж, эв нэгдэл, эртний Эзэнт гүрний хүчирхэг байдлаар дахин сэргээх оролдлого эхэлсэн боловч хаан ширээний төлөө цуст тэмцэл үргэлжлэхээс сэргийлэн Бурханы хувраг хутагтуудыг тодруулах замаар Монголчуудыг удирдан манлайлах, эвлэрүүлэн нэгтгэх лидерүүдийг тодруулах бодлого барьж эхэлсэн байна. Энэ нь эртний Алтан ургийн холбооноос илүү Энэтхэг, Төвдийн их мэргэд, хутагтуудын хувилгаан төрлийг Монголд тодруулах замаар хэрэгжсэн бөгөөд тэр үеийн Монголын тэргүүний дээд хан язгуурт ноёд тайж нар, тухайлбал Халхын гурван хан - Засагт хан, Түшээт хан, Сэцэн хан нар хэлэлцэж Монголын шашины тэргүүнийг тодруулсан үйл хэрэг нь

өөрөө Чингисийн алтан ургийн үйл хэргийг тасралтгүй үргэлжлүүлж, нэгэн үзэл санаа, нэгэн зүрх сэтгэлийн дор Монголын ард түмнийг нэгтгэж, Монгол үндэс угсаа, улс төрөө бадруулан мандуулах гэсэн их зорилт, их үйл хэрэг байсан юм. Энэ үйл хэргийн үзэл санааг хойч хойч үедээ тасралтгүй уламжлуулах арга болгож Бурханы гэгээрсэн хутагт дээд лам бодьсатва нарын хувтлгаан хойд дүрийг тодруулах, Бурханы шашины уламжлалыг монголчууд эзэн Богд Чингисийн үеэс уламжлалтай өөрсдийн дээд тэнгэр язгуурыг таслахгүй байх гэсэн үзэл санаан дор хүлээн авч, монгол хөрсөнд хэрэгжүүлсэн юм.

Ийнхүү монголчууд гэлүгбийн шашныг нийт монголчуудын шашин болгосны нэгэн гол шалтгаан нь бутралын үеийг даван туулахын тулд нэгдсэн төр улс байгуулж чадах тийм эзэн Богдыг тодруулах нь монголчуудын хувьд амин чухал зорилт болж байсантай холбоотой. Нөгөө талаар улс төрийн хатуу үйлийг шашин-номын ёсоор зөөлрүүлэн төв голч байр суурийг барих хос ёсны бодлогыг хэрэгжүүлж амжилтанд хүрсэн Хубилай сэцэн хааны үйл хэргийг үргэлжлүүлэх хүсэл эрмэлзэл бутралын үеийн Монголын бага хаадын хүсэл мөрөөдөл байв. Үүний хэрэгжилт болж Халхын гурван хан урьдчилан зөвшилцсөний дагуу 1639 онд Занабазарыг Монголын шашны тэргүүн “Богд Жавзандамба хутагт” хэмээн өргөмжилсөн нь угтаа шашин-номын ёсоор монголчуудыг эвлэрүүлэн нэгтгэж, Монголын нэгдсэн төрийг байгуулах үзэл санаан дор зохион байгуулагдсан үйл хэрэг мөн. Занабазарыг өргөмжилсөн “Богд”, “хутагт” хэмээх өргөмжлөлүүд нь тухайн үеийн монголчуудын хувьд

“тэнгэр заяат Чингис хаан” гэсэн утгыг далдуур илэрхийлж, Чингис хаан лугаа цэрэг дайны аргаар бус, үзэл суртлын аргаар монголчуудыг нэгтгэх, жирийн хүнээс ялгаатай, авьяас билиг төгөлдөр, онцгой дээд удирдагч төрсөн хэмээх итгэлийг өөрийн эрхгүй төрүүлж байв. XVII зууны эхэн үе гэхэд нэгэнт бичигдсэн байсан Монголын түүхэн сурвалжуудад Чингис тэргүүтэй Монголын их хаадыг Энэтхэг, Төвдөөс уламжлалтай хүрдэн эргүүлэгч Чакраварди хаадын тоонд оруулж, “Олноо өргөгдсөн”, “Чакраварди хаан” хэмээн нэгэнт өргөмжилдөг болсон нь тодорхой.

Монголчууд 300 жилийн бутралын үеийг даван туулах, нүүрлэн буй Манжийн эзлэн түрэмгийллээс нийгмийн материаллаг хүчин зүйлээр биш юмаа гэхэд нийгмийн сэтгэлзүй-ухамсрын хүрээнд сэргийлэх үүднээс эртнээс үндэсний бахархал, үлгэр дуурайлал, үндэсний удирдагч гэсэн утгаар алдаршуулж ирсэн “БОГД” хэмээх нэр алдраар XVII зуунаас эхлэн шашны тэргүүнээ тодорхойлсон нь угтаа үндэсний эв нэгдлээ оюун санаа-шашин шүтлэгээрээ баталгаажуулж байсны илрэл юм.

Өндөр гэгээнийг анх Их Монгол уулын энгэр, Ширээт Цагаан нуурын дэнжид ширээнд залах ёслол үйлдэх үеэр Монгол төрийн уламжлалт ёс дэгийн дагуу даншиг өргөх наадмыг зохион байгуулснаар ард олны дунд Чингис эзэн Богдоос хойш хүсэн мөрөөдөж байсан их “Богд” тодорсон хэмээх үнэнхүү баяр баяслыг төрүүлж, чин сүсэг бишрэлийг үүсгэсэн юм. Мөн Өндөр гэгээнийг 13 настай байхад нь буюу 1647 онд Түшээт хан Гомбодорж, Сэцэн хан Шолой нар түүнд зориулан “Баруун хүрээ”

(Шанхын хийд) хэмээн сүүлдээ олны дунд алдаршсан сүм хийдийг байгуулж өгснөөс гадна 1651 онд тэрээр Төв Халхын үзэсгэлэнт ууланд өөрөө Бүтээлийн сүм (Баясгалант аглаг орон) хэмээх Буддын гайхамшигт уран барилгыг сүндэрлүүлж, 1654 онд Хэнтийн нуруунд Их хүрээг, 1663 онд Шадивдаржалин хийд, 1702 онд Зүүн хүрээ, 1712 онд Шадивчойнхорлон хийдийг тус тус байгуулсан нь нэг талаас Халх Монголд Буддын сүм хийд өргөжин тэлэх үндэс суурь болсон, нөгөө талаас Монголын ард түмэн өөрийн гэсэн оюун санааны удирдагч манлайлагчтай болж, сэтгэл санааны хувьд шашин-соёлоороо нэгдэх нөхцлийг бүрдүүлжээ.

Анхдугаар Богдоос хойш 9 Богд тодорсны эхний 2 нь Монголоос, сүүлийн 7 нь Төвдөөс тодорсон ч, монголчууд анхнаасаа “МОНГОЛЫН ТЭРГҮҮН” гэсэн үзэл санаагаар Богд тодруулах асуудалд хандаж, нийгэм-улс төрийн нөхцөл байдлын эрхээр Төвдөөс залагдаж ирсэн Богдуудыг монгол сэтгэлтэй, монгол хэлтэй, Монголын төлөө хүн болгож хүмүүжүүлэхэд бүх анхаарлаа хандуулж ирсэн байдаг. Энэ нь мөн л “сэтгэлийг нь эзэмдвэл бие нь хаа холдох вэ” хэмээх эзэн Богд Чингисийн сургаал, үзэл санаагаар явагдсан үйл хэрэг гэж хэлж болно.

Монгол улс Манжид дагаар орсон үйл явдал Монголд гэлүгбийн буюу шарын шашин өргөн дэлгэрч эхэлсэн үйл явцтай давхцдаг нь тохиолдлын хэрэг бус аа. Монголчууд Манжийн ноёрхолын үед Манжийн хууль цаазын зэрэгцээгээр “Халх журам”-ыг хууль цаазын эрхтэйгээр дагаж мөрдөж байв. Хүрээ хийдэд онцгой эрх олгож, ард олон Манжийн засаг

захиргааны албанд зүтгэхээс илүү Богд Жавзундамба тэргүүтэй Монголын хутагтуудын биеийн ба эд хөрөнгөний албанд зүтгэхийг илүүд үзэх болсон нь угтаа Монгол хаандаа зүтгэж байгаатай ижил утгыг агуулж байлаа. Монголчууд бурхан шашнаараа нэгдэн, шашны тэргүүн Богдоо тойрон хүрээлж, түүхэн нөхцөл бүрэлдмэгц Монголын төрөө сэргээж, нийгэм-соёлоо дахин мандуулах сууриа бэлтгэж, Монголын хутагт лам хуврагууд зөвхөн шашин номын төдийгүй үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолынхоо төлөө нийгэм улс төрийн амьдралд идэвхийлэн оролцож эхэлсэн.

Монголын Богдууд бурханы шашин номыг Монгол газраа өргөн дэлгэрүүлж, шашин номоор нь монголчуудыг нэгтгэх, улмаар Монголын далд эдийн засаг, цэрэг хүчийг ч бэхжүүлж, тусгаар тогтнолоо олох зорилго тавьж байсан нь XIX зуунд Монголын бараг бүх сүм хийдээр зочилсон Оросын нэрт монгол судлаач А.М.Позднеевын дараахь тэмдэглэлээс харж болно.

“Халхын дөрвөн төрлийн хийдээс хамгийн баян бөгөөд том нь хутагтын хийд юм... Халхын ноёд сүм бариад хутагтад бэлэглэдэг. Тэгэхдээ ноён бүхэн хамжлагаасаа хэд хэдэн өрхийг таслан хутагтад үүрд эзэмшүүлэхээр өгнө. Тэр цагаас тэдгээр өрх тусгай засаг захиргаа болж, тухайн хутагтын шавь нар гэж нэрлэгдэх болжээ. Тэд урьдынхаа эзэнд төлж байсан алба гувчуураас бүрэн чөлөөлөгдөж, түүний оронд хутагтынхаа болон түүний хийдийн зардлыг даана. Хийдийн эргэн тойрны газар нь түүний нутаг ус болох бөгөөд засаг захиргааны хувьд хийдийн удирдлагадаа харьяалагдана. ...Жавзундамба хутагтын шавь нарын

тоо 20000 гаруй өрх... Хийд хийгээд хутагтын мэдлийнхнээс ажил төрөл хийдэггүй хүн гэж ганц ч байхгүй. Орон гэргүй болон ганц бие хүмүүс ихэнхдээ хийдийн мал сүргийг маллалцаж бараадан аж төрж, хийд дээр болохоор янз бүрийн ажил, үүрэг гүйцэтгэнэ. Ийм хүмүүсээс чинээлэгжиж гэр бүлтэй болсныг нь хийдээс гаргах бөгөөд тэд алба гувчуур төлөх болдог нь хутагтын нэгэн чухал орлого болно... Хутагтуудад онцгой ашигтай зүйл бол шавь нарын тээдэг аян жин юм. Хятад худалдаачид бараа таваарыг Хятадаас Монголд авчирч, Монголоос цагаан хэрэм дагуулан тээнэ. Эл тээвэртээ дан монгол жингийн хөсөг хэрэглэдэг. Тэгэхдээ баян жинчинтэй байх нь тэдэнд аль ч талаасаа ашигтай, аюулгүй... Одоо үеийн Халхад хийдийн чадлаас илүү малаар баян нь хараахан үгүй... Ер нь ямар ч байлаа гэсэн, шавь нарын жингийн алба хутагтуудад ихээхэн орлого оруулдаг бөгөөд түүний ачаар хутагттай хийдүүдийн жас ямар ч зардал гаргалгүйгээр өөрийн харьяат хамжлагчдынхаа хүчээр баяжиж байдаг. Хутагтын хийдийн дээрхээс илүү чухал орлого орлого нь өртөөний албаны гэрээ юм. ...Мал сүрэг, цайны гэрээр баянаараа хутагтын жас л энэ ажлыг гүйцэлдүүлнэ... Өргөөгөөс Улиастай орох шууд замын бараг бүх өртөөг хутагтууд гэрээлж авсан байдаг. Үүнд: Өргөөгөөс Чинтолгой хүртэлх өртөөг ихэнхдээ Жавзандамба хутагтын шавь нар, Тахилт болон Улаан шувууны өртөөг Оромбо гэгээний жас, Шувуут, Зуун модны өртөөг Зая бандидын шавь нар, түүнээс цааш Улиастай руу явах хэд хэдэн өртөөг Ялгуусан хутагтын хийд дааж байх жишээтэй. ...Хутагтын хийдүүд баян чинээлэг, оршин суух

лам нар олонтой хийгээд мөргөлчид энд бараг тасралтгүй ирж байдаг нь хятад худалдаачдыг ихээр татаж байдаг. Харин хүрээ хийдийн дэргэд худалдаа хийсний төлөө хятадууд яг тогтсон татварыг төлнө. ...Хутагтын хийдүүд басхүү мөнгө хүүлж улам хөрөнгөжих боломжийг олгодог байна. Үүнд, Жавандамба хутагтын жас хошуудад 3, 5, 8 мянган лан мөнгө байнга зээлдүүлж, түүнээсээ жилд 10-30 хувийн хүү авдаг.. Чингэснээр гэгээний жижиг сүм хийдүүд ч томорч, хутагтад шавь нар өргөсний хэрээр Халхын нэлээд нэртэй хийд болон хувирч байсан, хувирсаар ч байна” (Позднеев А.М. 2000, 4-8).

Ийнхүү Монголын хутагтууд хүрээ хийд, дацан сургууль байгуулах, ном бүтээл туурвих, урлаг соёлыг бүтээх зэргээр Бурханы шашин-номыг дэлгэрүүлэх оюуны үйл ажиллагаа явуулаад зогсохгүй Манжийн засаг захиргааны үйл ажиллагаанаас үл хамаарах, Манжид татвар төлдөггүй, лам нар нь Манжийн цэрэгт татагддаггүй сүм хийдийн биеэ даасан хүн хүч, эдийн засгийн үйл ажиллагааг явуулж байжээ. Энэ нь ламыг цэрэгт татдаггүй, сүм хийдээс татвар авдаггүй хууль журмаас гадна “Монголоо” гэсэн чин сэтгэлтэй олон түмний үнэн сүжигт тулгуурлаж байсан гэдгийг онцлууштай. Тиймдээ ч ХХ зууны эхээр Богд хаант тусгаар Монгол улс байгуулагдахад Монголын бүх хутагт хувилгаад түүнд шавь ард, лам-цэргээр болон мал сүрэг, эд мөнгөөр хүч нэмэгдүүлж, Монголын гэсэн “эр цэрэг, эдийн засгийн” хүчин чадлыг зузаатгаж байсныг А.М.Позднеевын дээрх судалгаанаас төвөггүй харж болно.

XVI зуунаас эхлэн тодорч эхэлсэн Монголын хутагт, хувилгаадын нийгмийн өмнө хүлээх гол үүрэг нь Монгол төрийн бодлого, ард түмний эв нэгдэл, Монгол ахуй соёл, үндэс угсааныхаа ариун дээд үзэл санаа, оюун сэтгэхүйг хадгалан үлдээж, өвлүүлэн уламжлах явдал байж, үүний төлөө тэд хичээнгүйлэн зүтгэж ирсэнд оршино. Монголчууд XVI зуунд бурхан шашнаараа нэгдэн, шашны тэргүүн Богдоо тодруулж байсан бол, XX зууны эхэн үеийн түүхэн шинэ нөхцөлд Монголын хутагт лам хуврагууд зөвхөн шашин номын төдийгүй үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолынхоо төлөө нийгэм улс төрийн амьдралд идэвхийлэн оролцож эхэлсэн юм.

Монголчууд аль болох Манжийн засаг захиргааны харъяаллаас ангид байхыг эрмэлзэж, Богд Жавзандамба хутагтыг Монголын шашны тэргүүн гэсэн утгаар ихэд дээдэлж, түүнийг зөвхөн шүтэж биширч байсан төдийгүй, биеийн хүчний хөдөлмөр зүтгэл болон санхүүгийн хувьд бүх талаар дэмжин тойрон хүрээлж байсан нь XX зууны эхэнд Богд хаант Монгол улс байгуулагдах нийгмийн сэтгэлзүй болон эдийн засгийн нөхцлийг бүрдүүлсэн гэж хэлж болохоор байна.

XX зууны эхэн гэхэд зөвхөн Богд тэргүүтэй хутагтуудын шавь ард төдийгүй Монголын дийлэнх эрчүүд шавьлан сууж байсан 800 орчим хийд орон бүгд Богдын удирдлаган дор нийгмийн үйл хэрэгт оролцоход бэлэн болсон байв. Энэ нь Монголд Ардын засаг байгуулагдсанаас хойш Богд тэргүүтэй Монголын хутагт хувилгаад, шавь ард, лам хуврагуудад тохиолдсон их хэлмэгдэл, тэдний мал сүрэг, эв хөрөнгө, соёлын өвийг

устгасны шалтгаан болсон юм. Учир нь энэ бүхэн ард олны бишрэл сэтгэлд тулгуурлан сүндэрлэсэн Богд хаант засгийн хүч чадлыг илтгэж байв.

Монголын хутагт хувилгаадын үйл ажиллагаанд дараахь үзэл санаа агуулагдаж байсан болохыг тэмдэглэе. Үүнд:

- Монгол үндэсний ахуй соёлыг уламжлан хадгалахыг хичээж ирсэн.
- Монгол үндэсний ахуйн болон оюуны соёлын хүрээнд монгол түмнээ нэгтгэх бодлого барьж байсан.
- Газар нутаг, бие даасан байдал, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байсан.
- Улс үндэстнийхээ ирээдүйн хувь заяаны төлөө санаа тавьж байсан.
- Монгол үндэснийхээ төлөө амь бие, сэтгэл санаагаа бүрэн зориулж байсан.

Ер нь ард түмэнд сэтгэлийн хүч, амьдралын урам зориг өгч, хөдөлмөр тэмцэлд уриалан дуудаж байдаг нийгмийн нэгэн чухал хүч бол олны дундаас тодорсон лидерүүд билээ. Лидер гэж их мэдлэг, өндөр чадвартай хүн гэхээс илүү ард түмнийхээ хүсэл зоригийг ойлгож мэдэрч байдаг хүнийг хэлдэг. Монголын хутагтууд нь Монголын үндэсний лидерүүд байсныхаа хувьд Монголын нийгмийн оюун санаа, ард түмний хүмүүжил соёл, нийгмийн ахуй амьдралд томоохон үүрэг гүйцэтгэж ирсэн юм. Тэдний хэлсэн үг, үйл ажиллагаа нь нийтэд үлгэр жишээ болж хүндлэгдэн дээдлэгдэхийн хэрээр олон түмэн тэднийг тойрон хүрээлж, нэгдмэл хүсэл эрмэлзлийн илэрхийлэл болж байв.

Өнөөдөр ч Монголын ард түмэн монголчуудын оюун санааг нэгтгэн залах хутагт хувилгаадаа тодруулах ажилд анхаарлаа хандуулж, ач холбогдол өгсөөр байгаа нь үндэсний тусгаар тогтнол, соёлын өвөрмөц байдал, хэл соёл, эв нэгдэл, ирээдүй хойч үеийнхээ төлөө санаа тавьж байгаагийн нэгэн илрэл билээ.

Харин 1921 онд Богд хаант

засгийг халж, БНМАУ байгуулагдсаны дараа, 1924 онд анхны үндсэн хууль батлагдсанаар Монгол улсад төр, шашин хоёр тусгаарлагдаж (секулярикац) эхлэсэн билээ. XX зуунд шинээр болон шинэчлэгдэн батлагдсан Монгол улсын Үндсэн хуулиудад шашны асуудлыг хэрхэн тусгасан байдлыг дараах хүснэгтээс харьцуулан харж болно.

Нэг. Засаглал

1924	1940	1960	1992
Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг 1924 оны 11-р сарын 26-ны өдөр Улсын анхдугаар Их хурлаар баталжээ	Монгол Улсын хоёрдугаар Үндсэн хуулийг 1940 оны 6 сарын 30-ны өдөр Улсын VIII Их Хурлаар баталсан байна.	Монгол Улсын гуравдугаар Үндсэн хуулийг 1960 оны 7-р сарын 6-ны өдөр баталсан.	Монгол Улсын дөрөв дэх буюу шинэ Үндсэн хуулийг 1992 оны 1-р сарын 13-нд БНМАУ-ын Ардын Их хурлаар баталсан.
Нэгдүгээр зүйл Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс хэмээж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино	Хоёрдугаар зүйл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улс төрийн үндэс бол феодалын байгууллыг унагааж, ард түмнээс улсын засгийн эрхийг байлдан олж, феодалууд /хан, ван, гүн, тайж, хутагт, хувилгаад/-аас өргөн олон ард түмэнд учруулж байсан улс төр, эдийн засгийн дарлал мөлжил, эрх ямба болон дураар эзэрхэх явдлыг устгасны үрээр үүссэн хөдөлмөрчин /малчин, ажилчин, оюутан/ ардын хурлууд болно.	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Гуравдугаар зүйл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн бүх эрх хөдөлмөрчин ард түмний мэдэлд байна. Хөдөлмөрчин ард түмэн өөрийгөө төлөөлсөн ардын депутатуудын хурлаар уламжлан засгийн эрх барина.	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Гуравдугаар зүйл. 1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. 2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.

Хоёр. Тэгш эрх

1924	1940	1960	1992
<p>Арван нэг. Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино.</p>	<p>Далан есдүгээр зүйл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүх ард иргэд нь яс үндсийг улсын засаг захиргаа, аж ахуй, соёл, боловсрол хийгээд улс төр, олон нийтийн бүхий л төрлийн ажил хэрэгт тэгш эрх эдэлнэ. ...Үндэстний дээрэнгүй байдал буюу дургүйцэл ба хялайн үзэл байдлыг ямар нэгэн аргаар нэвтрүүлэх явдлыг хуулиар залхаана. Наядугаар зүйл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотор эмэгтэйчүүд нь аж ахуй, улсын ба соёл, боловсрол, улс төр, олон нийтийн бүхий л төрлийн ажил хэрэгт эрэгтэй хүний нэгэн адил тэгш эрхийг эдэлнэ... Эмэгтэйчүүдийг богтлон өгөх, насанд хүрээгүй эмэгтэйчүүдийг эхнэр болгон өгөх буюу авах, олон эхнэртэй байх явдал, ...ямар нэгэн маягаар эмэгтэйчүүдийг боолын байдлаас ангижруулан гаргах ба тэгш эрхтэй болгох явдалд саадыг учруулбал хуулиар цээрлүүлэн шийтгэнэ.</p>	<p>Далан зургадугаар зүйл БНМАУ-ын иргэд эрэгтэй, эмэгтэй, арьс, үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрхтэй.</p>	<p>Арван дөрөвдүгээр зүйл. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p>

Гурав. Шашин шүтлэг ба сонгууль

1924	1940	1960	1992
<p>ЗУРГАА. Тус улсын харьяат аливаа хүний шүтэх итгэх явдалд бүрнээ эрх чөлөө олгохын тул шашны хэргийг улс төрийн хэргээс тусгаар байгуулж, шашин шүтлэгийн явдлыг өөр өөрийн дур сүгээр болговол зохино.</p>	<p>Наян нэгдүгээр зүйл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотор шашин шүтлэгийг улс ба сургуулиас тусгаарласан болно. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэн нь шашин шүтэх ба шашны эсрэг суртал нэвтрүүлэх эрхтэй болно.</p>	<p>Наян зургадугаар зүйл БНМАУ-д шашныг төр ба сургуулиас тусгаарласан юм. БНМАУ-ын иргэд шүтэх, бишрэх, шашны эсрэг суртал нэвтрүүлэг хийх эрх чөлөөтэй.</p>	<p>Есдүгээр зүйл. 1.Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ. 2.Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй. 3.Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.</p>

<p>Гучин тавдугаар зүйл. Аливаа Хурлын төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс: ГУРАВ. Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар</p>	<p>Далан нэгдүгээр зүйл БНМАУ-ын харьяат 18 насанд хүрсэн бүх ард иргэд эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, яс үндэс, эрдэм чадвар, нүүдлийн буюу суурьшлын байдал, хөрөнгийн байдлыг ялгаварлахгүй, гагцхүү ашиг олж хураах зорилгоор хөлсний хүчийг ашиглагчид ба мөнгө хүүлэгчид урьдын хутагт хувилгаад, дээд лам нар, жинхэнэ засаг ба засаг бус хан, ван, бэйл, бэйс, гүн түүнчлэн албад... хамжлагаа хатуу чангаар дарлан захирч явсан тайж нар, хошуу, шавь захирч байсан түшмэд, нөлөө бүхий бөө удган, цагаан цэрэгт ба хувьсгалын эсэргүү бослогод идэвхтэйгээр оролцогсод ухаан мэдрэл эвдрэгсэд хийгээд шүүх таслах газрын тогтоолоор сонгуулийн эрхээ хасагдаж шийтгүүлсэн хүмүүсээс бусад нь сонгуульд оролцох, сонгогдох эрхтэй болно.</p>	<p>Наян нэгдүгээр зүйл БНМАУ-ын иргэд нь шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан улс ба нийгэм, аж ахуйг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй. Энэ эрхийг ...бодит бололцоог бүх иргэдэд олгосноор хангана. Ухаан солиотой гэж нотлогдсон хүнээс бусад 18 насанд хүрсэн БНМАУ-ын бүх иргэн төрийн аль ч байгууллагад сонгох, сонгогдох эрх эдэлнэ.</p>	<p>Арван зургадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 9/шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно. 15/шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй; 16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх... эрх чөлөөтэй.</p>
--	--	---	---

Өнөө мөрдөгдөж буй “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хууль нь Монгол Улсын “иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулах” зорилготой. Үүнд, аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна, иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох,

хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэх мэтээр хүний эрхийн түгээмэл заалтуудыг тусгасан болно. Уг хуулиар Монголын төр, сүм хийдийн харилцааны үндэс нь “төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх” явдал юм. Энэ нь өмнө өмнөх үеийн Монголын төр, шашны бодлогын гүн ухааны үзэл санааг тусгасан чухал заалт билээ. Тухайлбал, төрийн НЭГДСЭН БОДЛОГО бол Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлж буй бүхий л бодлогын, түүний дотор шашны бодлогын суурь үндэс нь

байна, шашны бодлого бол эдийн засгийн, боловсролын, байгаль хамгаалах зэрэг Монгол төрийн бусад бүх бодлогуудтай нягт уялдан, нэгдсэн төрийн бодлогод захирагдах учиртай, чингэхдээ төр нь шашныг дорд үзэх, ялгаварлан гадуурхах, үл тоомсорлох байр суурийг хориглож, шашныг хүндэтгэх хандлагыг дэмжихээ илэрхийлсэн хэрэг юм.

Чингис хааны билиг сургаалд Монгол төрийн бодлогыг:

“Засахуй хэмээгч
Эрхэм ёсон буй
Засаглахуй хэмээгч
Засаг хууль буюу” хэмээсэн байдаг
бол шашны асуудалд хандахдаа:
“Сэтгэл хэмээгч
Биеийн эзэн буй за
Сэтгэл мунхарвал
Бие даруй доройтму” гэдгийг
санавал зохино гэж үздэг.

Энэ бүхнийг гүн ухааны үүднээс нэгтгэн дүгнэж, бодож боловсруулахын чухлыг зааж:

“Биеийн бөхөөр
Нэгийг дийлмүй
Билгийн бөхөөр
Мянгыг дагуулму” гэсэн буй.

Төр шашны харилцаа ямар байвал хамгийн зохимжтой вэ гэсэн асуултад гадаад дотоодын ихэнх судлаачид “төр нь шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөг хамгаалж дэмжиж байхад шашин нь төрийнхөө тусгаар тогтнол, иргэдийн амар тайван байдлыг хамгаалахад хүчин зүтгэж байвал төр, шашны харилцаа сая зөв явагдаж байна” гэж үздэг. Төрөөс шашны асуудлыг хамгийн зөв арга замаар шийдвэрлэх, шашны байгууллага, сүсэгтэн хүмүүстэй харилцах хамгийн зөв хандлагаа тогтоохын тулд Шашин

судлалыг шинжлэх ухааны салбар болох хувьд нь дэмжин хөгжүүлж, шашин судлаачдыг шашны асуудал эрхэлсэн төрийн үйл хэрэгт татан оролцуулах зайлшгүй шаардлага улам бүр өсөж байна. Шашин судлал гэдэг бол шашнаас ангид тусдаа байж, шашныг олон талаас судлан объектив мөн чанарыг нь тодорхойлох шинжлэх ухааны салбар болохоос шашныг баримталдаг, эсвэл шүүмжилдэг байр суурьтай субъект биш юм. Энэ утгаараа төр нь шашны асуудалд хандахдаа шашин судлалын шинжилгээ судалгааг үндэс болговол зохино.

II. Дүгнэлт

Орон бүхний шашинд хандах төрийн бодлого харилцан адилгүй байгаа нь тухайн ард түмний соёл уламжлалын түүхтэй салшгүй холбоотой бөгөөд түүхийн урт удаан хугацаанд чухам юуг суурь үндэс болгож ирсэн, өнөөдөр юуг чухалчлах талаар гүн ухааны үүднээс бодрол эргэцүүлэл явуулж, шинжлэх ухааны үндэстэй бодлого чиглэлээ ул суурьтай тогтоох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Монгол төрийн уламжлалт бодлогод шашин шүтлэгийг хүн ардын зүрх сэтгэлийн дотоод нандин учиг зүй гэж сайтар хүндэтгэн, болгоомж няхууртай хандахыг эрхэмлэж ирснийг өнөө ч хэрэгжүүлэх нь зүй. Шашин шүтлэг, шашны байгууллага, шашны үйл ажиллагаанд хандах нарийн төвөгтэй арга зүйг зөвхөн шинжлэх ухааны үндэстэй, тухайлбал “Шашин судлал” хэмээх шинжлэх ухааны бие даасан салбарыг түшиглэж боловсруулах аваас сая зөв гольдрилд орох боломжтой гэж олон орны шашин судлаачид үзэж байна.

Ашигласан материал

- Cavalli-Sforza L.L., Feldman M.W. 2003. The application of molecular genetic approaches to the study of human evolution. *Nature genetics* 5 (33): 266-275.
- ШУА, Түүхийн хүрээлэн. 2004. *Монгол улсын түүх. I боть*. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК.
- . 2004. *Монгол Улсын түүх. Тэргүүн анги. Хүй нэгдлийн байгуулал. I бүлэг. Чулуун зэвсгийн үе*. Улаанбаатар .
- Харузина В.Н. 1906. “Этнографическое обозрение.” 3 (4): 68.
- Сергей Токарев. 1984. “Символика огня в истории культуры.” *«Природа»* 9.
- Дамдинсүрэн Ц. 1959. *Монголын уран зохиолын дээж Зуун билиг оривой*. Улаанбаатар: ШУА.
- Цэрэнсодном Д. 1993. “Монголын нууц товчооны” эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Улаанбаатар: Үндэсний хэвлэлийн хороо.
- Лхагвасүрэн Г. 2004. *Шашины талаарх Монгол төрийн бодлогын уламжлалаас / Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө*. ред. Гангуяа М. Улаанбаатар.
- Солонгод Л., Хурцбаатар. 2019. *Хүйс толгойн бичээсийн судлал*. Кёльн.
2018. *Золотая орда обзор*. Vol. Том. 6.
- Рашид ад-Дин. 2002. *Судрын чуулган. II боть*. орч. Сүрэнхорлоо Ц. Улаанбаатар.
- Жувейни М. 2006. *Дэлхийг байлдан дагуулагчдын түүх*. орч. Бадамням М. Улаанбаатар: “Адмон” ХХК.
- ШУА, Түүхийн хүрээлэн . 2004. *Монгол Улсын түүх. II боть*. Улаанбаатар: ШУА, Түүхийн хүрээлэн.
- Ата Malik Juvaini. 1997. LXVIII. *The History of the World-Conqueror*. Translated by Boyle J.A. Manchester: Manchester University Press.
- Төгсбаяр Г. 2022. *Бөө Г.Төрбаярын сахиусны хүүрнэл*. Улаанбаатар.
- Агваангунгаасодномдагважалцан. 1630. *Сажийн хамба нарын намтар , (Саж дунраб) (Тувэд хэл дээр)*.
- Далай Ч. 1992. *Монголын түүх (1260-1388). Гутгаар дэвтэр*. Улаанбаатар: ШУАХ.
- Мансан Т. 2004. *Монгол үндэстний бүрэн түүх. II дэвтэр*. Улаанбаатар.
- Тэрбиш Л. 2008. *Ойрадын бурхан шашины товч түүх*. Улаанбаатар.
- Дашбадрах Д. 2012. *Дундад зууны үеийн Монголын түүхийн судалгаа. Боть II*. Улаанбаатар.
- ШУА, Түүхийн хүрээлэн. 2005. *Монгол Улсын түүх. Гутгаар боть*. Улаанбаатар: ШУА, Түүхийн хүрээлэн.
- Будсүрэн Д. 2011. *Цогт хун тайжид холбогдох түүхэн баримтын судалгаа*. Улаанбаатар.
- Базар Барадин. 2002. *Жизнь в тангутском Монастыре Лавран*. Улан-Үдэ, Бурятия.
- Хүрэлбаатар Л. 1996. *Огторгуйн цагаан гарьд*. Улаанбаатар.
- Тү.Өлзий. 2010. *Зуун гарын хаант улсын хаад / “Монгол хаад” цуврал*. Хөх хот, ӨМӨЗО.
- Чимэг О. 2001. Төвдийн Буддизм. Богд Зонхавын гэлүгба ёсны сургаалын товчоон. *Монголын философийн түүх (XVII XIX зуун). III дэвтэр*, by ФСЭХ ШУА, 105-106. Улаанбаатар: ШУА, ФСЭХ, “Бэмби сан” ХХК.
- Позднеев А.М. 2000. *Очерки быта Буддийских монастырей т Буддийского духовенства в Монголии*. орч. Лувсанцэрэн Г. Улан-Удэ. 2000. X.4-8. Орчуулсан академич Г.Лувсанцэрэн., Бурятия.